



Suma

Ching

Hai

News No.85

Төгс Урлаг

„Том“ Хэмээх нууцын тайлал

Багшийн "Эерэг хүчний ялалт" хэмээн нэрлэгдсэн Тэнгэрийн чимэг зүүлтний утга санаа

Тайвани Тайлэй хот дахь авшигтан номын ах Чен Тао Кү бичиж авшигтан номын энч Ванг Ксию Кинг эмхэтгэв.



Энэ өргөн уудам орчлон хорвоод Арга Билиг хэмээх 2 энерги оршин байдаг. Бид ихэнхдээ Арга-д нь амьдарч өдөр бүр маш олон сөрөг мэдээлэл, бодол санааг хүлээн авч байдаг. Ийм л учраас энэ дэлхий ядуу

тарчиг байдал, дайн дажин болон өвчин зовлонгоор дүүрэн байдаг. Хэрвээ бид энэ зовлонгийн далаигаас чөлөөлөгдж, цаашлаад энэ дэлхийгээ аврахыг хүсвэл бид эерэг, бүтээлч мэдээллийг оронд нь хүлээн авч байх хэрэгтэй. Ингэхийн тулд гэгээрэл хэмээгч цорын ганц зам бидэнд туслах юм. Гэгээрэл нь бидний дотор орших эерэг хүчийг дуудан сэрээж муунхаглалыг арилган бидний Арга Билгийг тэнцвэржүүлдэг." Эерэг хүчний ялалт" цуглуулгыг Багш бүтээсэн нь ийм учиртай. Тэрээр амьд амьтдын хэлбэлзлийг өндөрсгэн, тэдний сүнсийг ариусгах найдвар тавьж байгаа юм. Энэ бол "Тэнгэрлэг Чимэг" зүүлтний цуглуулгыг үзээд миний төрсөн бодол. Сувд нь Билиг ухааны гэрлийг харин молор нь Бурханы гэрлийг билэгдэнэ. Шунал, дур хүсэл тачаал г.м. сөрөг муу хүслийг илтгэгч-могой нь эдгээр 2 тэнгэрлэг гэрлийн нөлөөлэлд автан хайрын гэрэлд уусан эерэг хүч болж байна. Ийм учраас могойг цэвэр ариун алтан өнгөөр дүрсэлжээ. Үүний хажуугаар Багш нэгэн онцгой "∞" тэмдгийг оруулсан. Энэ нь 3 утга агуулгатай. 1-рт: "Төгсгөлгүй том". Бурханы хүчтэй нэгэнт холбогдчихвол бидний билгүүн ухааны гэрэл эгэл жирийн өртөнцөд ч тасралтгүй нөлөөлж байдаг. Үүнийг Бурханы хэмжээлшгүй гэрэл гэдэг. 2 дахь утга бол "Бурханы замаар чиглүүлэх нь" хэзээ ч төгсөхгүй бас эхлэлгүй. 3 дахь утга бол "Хүмүүн" юм. Tao Te Чинг-д үүнтэй хобоотой нэг хэсэг байдаг:

"Ертөнц үүсэхээс өмнө нэгэн хэлбэргүй, төгс зүйл байв. Энэ бол амарлингүй, амар амгалан, хоосон. Цор ганц, өөрчлөгдөшгүй, хэмжээлшгүй, хязгааргүй, мөнхөд орших зүйл юм. Энэ бол орчлонгийн эх билээ. Түүнд онож тохиорох нэр байхгүй учир би түүнийг Tao гэж нэрлэе. Энэ нь бүхий л зүйл дотор гаднагүй урсдаг ба бүхий л зүйлсийн эх язгуур руу эргэн буцдаг. Tao бол агуу. Орчлон өртөнц агуу. Дэлхий маань агуу.

Гариг өртөнц агуу...."

Дүгнэн хэллэхэд, Tao нь Диваажин болон Ертөнц бий болохоос өмнө үүссэн юм. Энэ нь бүхий л Бүтээлээс дээш оршдог хоосон ба нам тайван юм. Хаана ч хэзээ ч энэ нь өөрчлөгдөшгүйгээр тасралтгүй чиглүүлж байдаг. Бид үүнийг Tao гэж нэрлэдэг бөгөөд агуу хэмээх үг нь түүнийг хэзээ ч бүрэн гүйцэд тодорхойлж чадахгүй юм. Дээрх ишлэлээс үзвэл Tao нь "Том" хэмээн тодорхойлогдож болдог. Хятадын ханз үсгээр (зурагт дурс) "Том" гэдэг үг нь хүн 4 мөчөө сунгахыг илэрхийлдэг. "∞" тэмдэг нь Tao-гийн үйл ажиллагааг билэгдсэн 2 дугуйг дүрсэлдэг. 1 тойрог нь толгойг, харин нөгөө нь их биеийг төлөөлөн дүрсэлдэг. Гуань Иний аргаар бясалгагч хэн ч 2 тойргийг холбож буй хэсэг нь билгийн нүдийг билэгдэн үзүүлж байна гэдгийг мэддэг. Хоёр зам болон эсрэг чиглэлээр эргэлдэх 2 дугуй нь ариун орон болон бузар оронг хоёулангийн замыг зааж байдаг. Диваажин болон эх дэлхий, Хүн төрөлхтөн нь мөн Tao-гоос ангид тусдаа "Том" юм. Тэгхээр хүн гэгч нь хэр том юм бэ? Буддагийн сударт "Хүн бол бүхий л орчлонг өөртөө агуулдаг" гэсэн байдаг. Диваажин, Там хүртэл бидний дотор байдаг юм. Энэ ховор нандин хүний биеийг зөв ашиглан бясалгал хийж дотоод дахь "Диваажин Бурханы орон" болон Бурханыг олох хэрэгтэй. Хэдийгээр Бурханы орныг таних замд маш олон чөтгөрийн саад тогторууд байдаг ч бид нэгэнт дотоод дахь Бурханаа олчих юм бол энэ нь "Эерэг хүчний ялалт" болох болно!

Taurus

*Миний эзүүний тэртэй тэнцэлжээ,
сүр эхавчлангааф дүүрэн
олон орд харьш бий.*

- ## 2. “Дахин сануулга” олон орд харш бий.



- | | |
|---|---|
| <p>12. “Билгүүн ухааны сувд
Эгогийн ов мэх, башир арга”</p> <p>13. “Тэрлэлтийн талаархи
төөрөгдөл”</p> <p>14. “Мөнгөн Сарны Гэрлийн Дор”</p> <p>21. “Бялхаж буй аз жаргал”</p> <p>22. “Төгсгөлгүй хайр,
Дуусашгүй зовлон”</p> <p>23. “Бурхан Абрахамыг
шалгасан нь”</p> <p>29. “Z” (зэт) гаригийн түүх”</p> <p>“Бидэнд байдаг зүйлс маань
бидэнд хамгийн
тохиромжтой нь юм”</p> <p>32. “Зөв гэсэн зүйлээ
зоригтойгоор хий”</p> <p>33. “Хамгийн түрүүнд Бурханыг
эрж хай, тэгвэл бусад бүх
зүйл чам руу ирэх болно”</p> | <p>34. “Бяцхан хэрэмний үнэн
түүх”</p> <p>37. “Харь гаригийнхантай
уулзсан нь”</p> <p>“Айдастгүй бяцхан
Бодисадва”</p> <p>38. “Урлагийнхны тоорогдол”</p> <p>40. “Аймшигт хар тамхи”</p> <p>41. “Амьдралын дараах
амьдрал”</p> <p>42. “Билиг оюуны замд орсох
азтай гэр бүл”</p> <p>43. “Таны Толоо Гэрэлтэн
Асч Буй Дэнлүү”</p> <p>“Би Хэн Бэ?”</p> |
|---|---|

Их Багш Чин Хай ном
айлласан нь.
Лос Анжелес. АНУ.
1997.07.06.

Дахин сануулга

зөвхөн суух ч биш өдөр бүр
бясалгах хэрэгтэй. Өдөр
тутмын энэ үйл явц нь илүү
амар тайван, илүү дотогшоогоо
чиглэсэн байж гэмээнэ бид өөрсдийн
тэр жинхэнэ Бурханлиг шинж чанарын эх
үүсвэртэй холбогдож чадах юм. Тэндээс
л бид өдөр тутмынхаа амьдралын элдэв
асуудал, зовлон бэрхшээлийг шийдэж
улмаар амар амгалан болдог. Хэрвээ бид
өөрсдийн эд эс, тархи цусаа самууруулбал
энэ “эмзэгүян хэсэг” маань ч бас самуурдаг.
Тэгээд бид шууд шулуунаар бодож
чадахгүй, бясалган суух үедээ ч тайван
амгалан бус, сэтгэл түгшсэн, санаа зовсон
байдалтайгаар суулаа ч бидний хараа,
билиг оюун маань биедээ оруулсан хорт
бодисын сөрөг муу нөлөөнд халхлагддаг.
Тиймээс Бурхан бидний юу идэж буйд
санаа тавина гэсэн үг биш, эсвэл жаахан
мах идэхэд л шууд там руу явна ч гэсэн
үг биш юм. Энэ бол худлаа. Энэ нь ердөө
л, хэрвээ Бурхантай адил байхыг хүсдэг
юм бол бид өөрсдийн хийж буй бүхий л
зүйлдээ, идэж буй бүхий л зүйлээ цэвэр
эсэхэд санаа тавьж анхаарах хэрэгтэй.
Ингэж л бидний бие, хэл, сэтгэл ариун байх
болно. Би та нарын юу идэж байгаад санаа
тавихгүй, гэвч юу иднэ тэр чинь та нарын
бясалгал, дадал, зан ааш, сэтгэл санааны
байдал, хувийн шинж чанар, амьдралыг
үнэлэх үнэлэмжинд чинь нөлөөлнө. Бүх
зүйл үүнээс шалтгаалдаг. Нэгэнт бид
материаллаг ертөнцөд байгаа учраас
материаллаг зүйлс бидэнд нөлөөлсөөр
л байх болно. Тиймээс л бид үүн дээр
анхааралтай байж өөрсдөө багахан
дараа төвөг болох, илүү цэвэр, үйлийн
үр багатай хоол хүнсийг сонгож хэрэглэх

Бидний аялал авшиг хүртсэнээр эхэлдэг. Ингээд та өөрийн амьдралаа илүү сайн тал руугаа болсныг мэднэ. Бас Дөхөм арга заалгаад хэсэг бясалгасны дараа амьдрал тань өөрчлөгдж, өмнөхөөсөө ч илүү сайжирсныг та мэдэрдэг. Тийм биш гэж үү? (Сонсогчид: Тиймээ). Тиймээс л та нар энд дахин дахин ирээд байгаа юм. Өнөөдөр та нар өмнөхөөсөө ч илүү ухааран ойлгочихоод байгаа ба адислал, баяр баясгалан ч мэдээж өмнөхөөсөө их байх болно. Та бүхэн илүү сайхан, амар амгалан, урсам зөөлөн амьдралдаа баясч, өмнө нь хүнд хэцүү байсан зүйл маш амархан болж, шийдэж чадахгүй байсан бүхий л асуудал бэрхшээлүүдээ одоо бол маш амархан, хурдан, илүү тодорхой байдлаар шийдэж чадах болно. Тиймээс цаг гаргаад бясалгалаа өдөр бүр хийж байгаарай. Өөрийгөө болон эд эс, уураг тархиа бохирдуулах самуун идээ ундаанд анхаарал болгоомжтой хандаж бай, эс бөгөөс эдгээр нь өөрийн тань билиг ухааны өсөлтөнд саад учруулах болно шүү. Бурхан бидний юу идэж буйд санаа тавьдаггүй. Гэвч хэрвээ бид мах, амьтны гаралтай хүнс мөн мансууруулах бодисоор өөрсдийгөө хордуулах юм бол бидний тархи болон биеийн эд эсүүд мөн л үймэрч самуурна. Ингээд бид юмыг саруул todoor бодож сэтгэж чадахаа больж амар амгалан, билгүүн ухааныхаа эх булгийг олох гэж тайван ч сууж чадахаа больдог. Бид амар тайвнаар суух хэрэгтэй, гэвч

хэрэгтэй. Амьтад маш их зовж байна. Тэд үхлээс айж, амьдрал руу тэмүүлж байна. Хэрвээ тэд бидний төлөө зуурдаар үхэхэд хүрвэл мэдээж тэдний айdas үзэн ядалт бидний идэж буй зүйлд шингэж үлддэг. Иймээс л бид түрэмгий, сэтгэл түгшсэн, заримдаа тэдгээр амьтдын үхэхээсээ өмнө мэдэрч байсан догшин ширүүн зан байдлыг гаргадаг. Ургамал ногоо бас мэдрэхүйтэй, яг ч мэдрэхүй бус зүгээр л хариу үйлдэл юм. Гэвч тэд амьтадтай адил тийм амьдралын мөчлөггүй байдаг. Ургамлын айdas нь тийм ч их хүчтэй биш. Түүнээс гадна тэд дахиад ургачихна. Мөн нэг модны мөчрийг тайрлаа гэхэд тэр хоёр, заримдаа бүр гурав болоод л ургачихдаг. Тиймээс бид мод тайрч унагалаа гэхэд энэ зүгээр. Гэхдээ илүү их мод тарьж байгаарай. Мөн З дахин илүү ургуулахын тулд бид мөчрийг нь тайрдаг шүү дээ. Энэ бол зүгээр. Бид байгалийг тахин шүтдэггүй харин ашигладаг бөгөөд өөрсдийнхөө төлөө түүнийг хамгаалж байдаг юм. Хүн төрөлхтөн 1-рт тавигдах ёстай. Зарим хүмүүс хэтэрхий туйлширсан байдаг. Тэд хэлэхдээ: “За тэгвэл, ургамал ч бас амьтай болохоор бид түүнийг идэхээ болье” гэдэг. Тэгэхээр нь би “За тэгвэл үхдээ, үх” гэдэг. Бид туйлшрах ёсгүй, бид бүх зүйл дээр дундыг баримтлан эвтэйхэн аргаар хийдэг. Энэ нь яг одоо бидний бясалгаж байгаа байдалтай адил юм. Бид бүтэн өдөржин биш харин өдөрт 2 цаг 30 минут л бясалгадаг. Бид бүх үүргээ биелүүлчихээд амарч тайвширсныхаа дараа бясалгахаар суудаг. Та нар 2 цаг 30-аа нэг суултаар л дуусгах алба байхгүй. 1 цаг суугаад ядраад байвал босчих. Өглөөдөө илүүхэн бясалгах хэрэгтэй. Дараа дахиад суухад ядрахгүй байвал илүүхэн суучих. Тэгээд энэ чинь нэмэгдээд байна. 2:30 эсвэл 3 цаг байхад энэ болно. Заримдаа та нар нийлээд нэг долоо хоног эсвэл хоёр долоо хоног бясалгадаг. Тэгэхдээ бүтэн өдөржин сууж болно. Энэ нь та нар маш сайн юм. Мөн та нарын бясалгалаа хийгээгүй эсвэл хангалттай бясалгаж чадаагүй өдрүүдийг чинь нөхөх болно. Тиймээс бидний танилцуулж байгаа зүйл та нарт маш их ашиг тустай. Үүнд ямарч

дүрэм журам, заавар байхгүй. Үнэндээ сахил ч гэж байхгүй юм. (Энэ чинь зүгээр л бид амьдралдаа эрхэм дээд, ариун ёсоор амьдрах арга хэлбэр юм). Яагаад гэвэл, хэрвээ хүн болгон та нар шиг амьдардагсан бол энэ дэлхий диваажин байх байсан. Үнэхээр тийм болох байсан. Дэлхий дээр маш их дайн самуун, аюул гамшиг тохиолдож байна. Учир нь бидний ихэнх нь Бурханы бидэнд илгээсэн тэр сайхан эрхэмсэг амьдралаар амьдрахгүй байгаа юм. Бидний ихэнх маань өөрсөддөө байгаа тэр Бурханлиг шинж чанараар амьдрахгүй байна. Бид өөрсдийнхөө Бурханлиг шинж чанарыг булшлан оронд нь ертөнцийн шинж чанараа хэтэрхий их хөгжүүлж байна. Иймээс л бидний амьдрал тэнцвэргүй байгаа бөгөөд бүх зүйл илүү материаллагжин, харин хариуд нь гай гамшиг болон тэмцэлдэгч байдлыг урин дуудаж байна. Бие биентэйгээ тэмцэлдсэнээр дайн дажин, зөрчил тэмцлүүд олон улс даяар гарч байна. Тиймээс бидний явж буй энэ амьдралын зам бол хамгийн шилдэг, хамгийн эрхэм дээд, хүн болгоны явах хэрэгтэй тэр зам мөр юм. Гэвч хүн болгон энэ замаар явахгүй байгаа нь энэ дэлхийн хамгийн харамсалтай зүйл юм. Би зүгээр л та нарт өнөөдөрээс эхлэн явахаар сонгосон зам чинь төгс төгөлдөр гэдгийг л сануулах гэсэн юм. Тиймээс энэ замаараа үргэлжлүүлэн явахыг өөртөө сануулж байгаарай. Хуучин авшигтнууд ч гэсэн сонгосон зам чинь төгс гэдгийг мөн санаарай. Бидний одоогийн сонгосон замаас илүү дээр зам гэж байхгүй, илүү дээр амьдрах амьдралын хэлбэр гэж байхгүй юм. Ямар ч өөр сонголт сонгосон бай хамаагүй та нар зовох болно. Тиймээс бидний энэ явж байгаа зам, бясалгалаа хийж сөрөг муугаас татгалзан өөрийн амьдралаа хянаж, үүнийгээ хүнлэг энэрэнгүй, тодорхой зорилготой болгож чадах ганц сонголт бол энэ зам юм. Өөр сонголт байхгүй. Өөр сонголтыг сонголоо ч энэ нь сайн биш байх болно гэдгийг та нар мэдэж байгаа. Ийм л учраас та нар үлдэх хэрэгтэй бөгөөд үүнийгээ ч мэдэж байгаа. Би зөвхөн, та бүгдийн сонгосон зам чинь хамгийн шилдэг нь гэдгийг л хэлэх гэсэн

С
Б
А
Г
Ш
И
Й
Я
Р
И
А

юм. Энэ нь бидэнд өөрсдөд маань болон дэлхий өртөнцөд сайн, хүн бүхний дагавал зохих үлгэр жишээ амьдралын зам учраас би та нарыг энэ сонголтондоо бат зогсоно гэдэгт итгэж байна. Бид хөршөө үүнийг хийж эхлэхийг хүлээх хэрэггүй. Бид эхлээд хийгээд тэгээд хөрш маань биднийг дагах болно. Нэг хүнээс эхлэхэд түүнийг олон хүн дагах болно. Гэхдээ зөвхөн ганцаас л эхэлсэн, надаас, тэгээд л та нар надаас жишээ авч байгаа. Таны гэрэл гэгээнээс хичнээн олон мянган хүн илүү гэгээлэг, аз жаргалтай болж болохыг хэн мэдэх билээ? Тиймээс та бол маш чухал. Нэг хүн-чухал, хоёр хүн – илүү чухал, нэг хэсэг хүмүүс-энэ дэлхийд маш их чухал юм. Авшиг авсан тэр өдрөөс л таны бясалгальн энери

хүчээс болох ёстой байсан дайн бололгүй зогсож, олон аюул гамшиг багассан байгаа. Та бүгд анзаарах болно. Хүрээлэн буй орчин тань хүртэл сайжирна, илүү сайхан харагдана. Мод цэцэгсээс гэрэл цацарч, сэтгэлийг тань баясган, гишгэж буй зам тань хүртэл гэрэлтэн бүх зүйл тэр аяараа сайжирна. Та нараар дамжуулан маш олон хүн энэ замыг даган мөрдөж ижил үр шимийг хүртэх болно. Тиймээс ч би та бүхэнд энэ дэлхийн сайн сайхны төлөө бидэнтэй нэгдэж байгаад талархаж байна. (Алга ташилт) Би та бүхэнд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн өрөө! Бурханы адислал та бүхэнтэй үүрд хамт оршино. Үүнд эргэлзэх зүйлгүй. Үнэхээр эргэлзэх зүйлгүй. (Алга ташилт)



Онч мэргэн чус

*Санаанг таафахгүй ямар л зуффшил байна
түүнийг устгаж хаяхыг хичээ. Мөн илүү тогс,
эрхэм дээд гээж бодсон юу л байна, түүнийгээ
өөрийн хүч чадал, цаг хугацаа, чин сэтгэл,
чармайлт оролцлого бүхэндээ шингээх хэрэгтэй.*



*Саад тогтор нь биднийг сүргаж
дадлагажуулахын тулд байдал. Саад бэрхшээлтэй
нүүр тулхаас хэзээ ч бүч аиж хулчий. Үргэлж
түүнтэй нүүр тулах зоригтой бай.*



Үхэл ба гэгээ

Их Багшийн Коста Рика-ийн Сан Жайсү
тавьсан лекц
1989.11.22

Өнөө орой би та нарт хэн нэгэн энэ дэлхийг орхисныхоо дараа юу болдог талаар зарим нэг ойлголтыг өгье. Яагаад гэвэл бид энэ дэлхийд амьдарч байхдаа юу хийхээ аль хэдийнэ мэдэж байдаг. Ихэнх хүмүүс энэ дэлхийгээс явахад юу болдгийг мэддэггүй. Би ч гэсэн “үхэл” гэж нэрлэгдэх ахуй ойлголт гэгээрэл хоёрын хооронд харьцуулалт хийхийг хүсч байна. Бид үхэх үедээ үнэндээ жинхэнээсээ үхдэгтүй юм. Бид зүгээр л гадаад физик дүрээ л өөрчилдэг, эсвэл заримдаа бид богино хугацаанд магадгүй урт хугацаанд, 100 жил, олон хоног, олон мянган жил энэ махан биеэ орхидог юм. Тэгээд бид дэлхий дээр дахин ирж энэ физик төхөөрөмжөөрөө (биенэрээ) өөрсдийн билгүүн ухаан, туршлагаа дахин илэрхийлж болно.

◆ Эзэлэл бол өдөр болгон үхэх

Библи дээр нэгэн гэгээнтний өгүүлснээр, тэрээр ”Өдөр бүр үхдэг” гэсэн байдаг. Өөр нэг хэсэгт ”Амьдрахын тулд бид эхлээд үхэж сурх ёстой” гэсэн байдаг. Мөн ”Хэрвээ та бүхэн амьдралаа золиослох юм бол амьдралаа тэтгэх болно” гэсэн байдаг. Тиймээс бид Библийг уншихдаа иймэрхүү өгүүлбэртэй тааралдвал ихэд будилж төөрөлддөг. Үхэж сурх нь чухал юм. Тэгж байж та амьдарч эхлэх болно. Мөн өөр нэг хэсэгт ”Та амьдралаас татгалзвал амьдралыг олж авах болно” гэж дурдсан

байна.

Тийм болохоор бид Библи уншиж байхдаа иймэрхүү өгүүлбэрүүдтэй тааралдаж үүнд бүр будилж төөрөлдж орхидог. Амьдрахын тулд үхнэ гэдэг нь юу гэсэн үг вэ? Хүн өдөр бүхэн үхэж чадна гэж үү? Яаж бид нар амьдралыг олохын тулд амьдралаас татгалзах вэ? Энэ нь боломжтой гэж үү? Та нарын олонх нь ”Амьдралын дараах амьдрал” гэдэг номыг уншсан байх гэж бодож байна. Энэ номонд нэгэн америк эмч үхээд амилсан хүмүүсийн талаарх түүхүүдийг цуглуулан эмхэтгэсэн байдаг бөгөөд тэдний ихэнх нь нэгэн ижил туршлагуудыг өгүүлж байсан юм. Тэд үхээд энэ физик махан биеэ орхимогц маш их баяр жаргал, эрх чөлөөг мэдэрч, бүр маш алс холын орон руу нэгэн хонгилоор яван очиж гэрэл гэгээ, хайр энэрэл, дүүрэн төрөлтнүүд тэднийг угтан авч байсан гэнэ. Гэгээрэл гэж нэрлэгдэх тэр ахуй ойлголтыг үзэх үед бид үүнтэй ижил зүйлийг үзэж туулах болно. Ийм л учраас ”Би өдөр бүр үхдэг” гэдэг юм. Гэгээрэл гэдэг нь, бид илүү өндөр, дээд ертөнцийн өндөр давтамжтай холбогдоно гэсэн үг. Бид энэ орчлон ертөнцөд ганцаарханаа оршдоггүй бөгөөд бидний, одоо амьдарч буй амьдрал маань ч бидэнд заяасан эхний бөгөөд эцсийн ганц нь биш юм. Тиймээс, хэрвээ бид гэгээрэл хэмээх ахуй ойлголтыг олж авбал энэ нь бид яг тэр цаг хугацаанд илүү өндөр дээд ертөнцтэй холбогдсон байна гэсэн үг бөгөөд заримдаа бидний өнгөрсөн үе дэх сүр жавхлант ертөнцийн сүр жавхлант ахуй ойлголтууд дахин төрж байдаг юм. Бид үргэлж хүн төрөлтэн байгаагүй, бид заримдаа Будда, сахиусан

С
Б
А
Г
Ш
И
Н
Я
Р
И
А

6 Чин Хайн Шэдээ

тэнгэр, гэгээнтэн, Бодьсадва нар байсан. Бодьсадва гэдэг нь Христ нэр томъёогоор Гэгээнтэн гэсэн утгатай. Энэ нь зөвхөн Санскрит хэлнээс оруулагдаагүй нэр юм. Бодь гэдэг нь “Гэгээрсэн”, Садва гэдэг нь “Төрөлтөн” гэсэн утгатай.

Бид өнөөг хүртэл өөр, өөр ертөнцөд маш олон төрөлдөө амьдарч байсан. Зарим үед бид маш сүр жавхлант оюунлаг ертөнцөд амьдарч байсан. Гэвч бидний ихэнх нь энэ ертөнцөд ирэхдээ өнгөрснөө бүгдийг мартдаг. Харин бид гэгээрэх үедээ эдгээр өнгөрсөн дурсамжуудаа заримдаа эргэн санах болно. Тэгээд бид байх ёстой газраа, ирсэн газар руугаа эргэн очих боломжтой болдог бөгөөд бид хичнээн агуу төрөлтнүүд гэдгээ эргээд мэдэрч эхэлдэг юм. Энэ нь яг л зарим хүмүүсийн үхэх үеийн мэдрэмжтэй адил юм. Ихэнх хүмүүс үхэл гэж нэрлэгдэх туршлагыг үзэж туулах үед, туулсан өнгөрүүлсэн бүхий л амьдрал нь нүднийх нь өмнө яг л кино шиг гарч өнгөрдөг байжээ.

Гэвч ихэнх үхсэн хүмүүс зөвхөн энэ амьдралынхаа дүр зургийг хардаг. Харин гэгээрсэн нэгэн нь ганц энэ дэлхий, энэ амьдралаа харах бус өнгөрсөн мянган мянган, зуун зуун жилийн төрлөө, ганц энэ дэлхий бус бусад гаригт байснаа хардаг.

Зөвхөн энэ ертөнц дээрх ч бус бас өөр ертөнц дээрх амьдралуудаа олж харж чаддаг. Тиймээс хэн нэг хүн иймэрхүү мэдлэг, туршлагатай болсныхоо дараа тэрээр өөрийгөө жирийн бус харин Будда, эсвэл Христын мэдрэхүйтэй гэдгээ мэдэрдэг. Иймээс л Есүс өөрийгөө Бурханы хүү, Будда Өөрийгөө гэгээрсэн нэгэн буюу Будда гэж зарласан юм. Будда гэдэг нь мөн л Христ гэсэн утгатай. Христ гэдэг нь Бурханы ухамсырын түвшин гэсэн утгатай. Тиймээс Будда бол Христын Санскрит нэр Христ бол Буддагийн Хебрю нэр томъёо юм. Бид хэрвээ ухаарал ойлголтын иймэрхүү түвшинд очих юм бол мөн өөрсдийгөө Будда, Христ гэж мэдрэх болно. Хэрвээ бид өндөр дээд гэгээрэлд хүрэхгүй юм бол бид зөвхөн үхэл хэмээн

нэрлэгдэх туршлагыг үзэх болно. Энэ дэлхийг орхисныхоо дараа бид Асурийн түвшин эсвэл бага зэрэг дээд ертөнцөд очиж болно. Гэвч бид илүү өндөр түвшний гэгээрэл, илүү өндөр түвшний мэдлэг чадварыг өдөр тутмын бясалгал дасгалаар олж авах юм бол илүү өндөр билиг ухаан, сүр жавхланг илэрхийлэгч өндөр дээд ертөнцөд хүрч чадах болно.

Есүс хэлэхдээ “Миний Эцгийн гэрт маш олон орд харш бий.” гэсэн байдаг. Тиймээ, Энэ бол түүний хэлсэн үг байсан юм. Библи дээр хэн нэгэн 3-р ертөнцөд хүрсэн тухай байдаг. Библи дээр хэдэн ертөнц байдаг талаар хэлсэн зүйл байхгүй гэхдээ 3-р ертөнц гэж байдаг юм бол 4 дэх, 5 дахь гэж байх л ёстой юм.

Үүнтэй адилаар Буддизмд Будда маш олон Буддагийн орны талаар дүрсэлсэн байдаг. Жишээлбэл, Тэнд Amitaba

Буддагийн орон гэж бий. Энэ орон багаасаа их рүүгээ нийт 9 түвшинд хуваагдана. Ач тус, буян бага, бясалгал багатай нэгэн нь үүний доод түвшинд хэдэн мянган жил болдог. Тэрээр өндөр дээд Будда эсвэл гэгээрсэн төрөлтнүүдийн өдөр тутмын сургаал заавраар аугаа сэхээрлийг олох хүртлээ тэндээ байдаг. Тэгээд тэрээр мөн л илүү өндөр түвшинд очих болно.

Миний бодлоор энэ нь яг л бидний сургуультай ижил төстэй юм. Дээд сургуульд илүү олон ангитай байдаг. Одоо бид гэгээрэл хэмээх ойлголтыг үзэж туулах үед энэ нь яг л бидний үхэж буйтай төстэй юм. Бид зөвхөн энэ физик махан биеэ түр зуур орхиод л эргэж ирдэг. Энэ нь тэр Америк эмчийн номон дээр гардагтай төстэй юм.

❖ *Хэлд өвлэүүс*

Үхлийг ийм зовлонтой хэцүү санагдуулдаг зүйл бол үхэлд бэлэн бус байгаа явдал юм. Хэрвээ бид өдөр бүр хэрхэн үхэхийг сурчих юм бол энэ нь маш аятай тааламжтай байх болно. Ихэнх

хүмүүс үхэх үедээ энэ дэлхийг орхин явна гэхээс маш их айдаг. Учир нь тэд энэ дэлхийгээс илүү дээр, илүү үзэсгэлэнтэй, илүү тааламжтай, илүү аз жаргалтай өртөнц тэднийг хүлээж байгаа гэдгийг мэддэггүй юм. Тэд танил болсон хүрээлэн буй орчин, мөн хайртай хүндээ хоргоддог. Ингэж сүнсэн бие маан бие хоёр хоорондоо тэмцэлдэж тэгээд л энэ нь ихэд зовлонтой болдог юм.

Хэрвээ бид үхэл гэдэг чинь зөвхөн л дахин төрөхийн хэлбэр юм гэж ойлговол айхгүй. Цаг нь ирэхэд бид баярлах болно. Одоо яж энэ сайхан өдөрт бэлдэх вэ? гэдэг тухай ярья. Олон хүмүүс төрөхөд бэлддэг, хурим хийхдээ бэлддэг. Гэвч үхэлд ер бэлддэггүй. Үнэн хэрэгтээ үхэл нь хамгийн том өдөр. Хамгийн чухал өдөр байх ёстой. Төрөхөд бид зөвхөн маан биетэй л болдог. Хязгаарлагдмал эрх чөлөө, маш удаан өсөж том болох үйл явц. Гэвч үхэхэд бид илүү саруул уудам эрх чөлөө, маш голоо үзэсгэлэнтэй, уян хатан бие, агуу их билиг ухаан, илүү үзэсгэлэнтэй сайхан амьдрах оронг олж авдаг. Түүндээ унтаж амарч, сурч боловсорч, өсөж хөгжин, дэвшин дээшлэх бүрэн боломжтой юм.

Ингэхлээр, үнэндээ үхэл гэдэг бол бидний хөгжил хувьслыг хурдасгах, илүү өндөр билиг ухааны түвшинд, илүү хурдан хөөргөн аваачихад маш тустай үйл явдал юм. Гэхдээ, үхсэний дараа дээрх байр байдлыг олж авахын тулд бид энэ өртөнцөд амьдрах явцдаа илүү сайн сайхан, ач тустай, тааламжтай, аятай байх тал дээр анхаарах хэрэгтэй юм. Ингэснээр бид энэ өртөнцийг орхих үедээ ямар нэгэн харамсах, гэмшиг сэтгэлгүй ямар нэгэн татаас хүлээсгүйгээр маш хурдан бөгөөд аз жаргалтайгаар хөөрөн явах болно. Хүн энэ маан бие орхисныхоо дараа тэдний зовлон дээр нь өөр бусад бэрхшээлүүд, (ард үлдэж буй хүмүүсийн уйтгар, харамсал гашуудал) нэмэгддэг. Ихэнххүмүүс хайртай хүнээ үхэх үед уйлж маш олон сар жилээр харамсан гашууддаг. Ийм зүйл яагаад

болдгийг бид ойлгож байна. Учир нь бид бүгд гэгээрч өөрсдийн хайртай хүнээ, сайн наизаа, хамтрагчаа алдсан. Бид тэднийгээ хаашаа явж байгааг, энэ дэлхийг орхисны дараа түүний амьдрал нь эндэхээс илүү сайн болсон эсэх, түүний талаар хэн нэгэн санаа тавьж байгаа эсэхийг мэддэггүй юм.

Тиймээс ч тэдгээр нас нөгцсөн сүнснүүдийн төлөө харамсан гашуудаж тэдэнд татагддаг юм. Энэ мэдрэмж, сэтгэл нь тэдгээр нас нөгцсөн сүнснүүдийг барин зарим нэг байдлаар уяж хүлдэг юм. Мөн түүний баяр баясгаланг багасгаж эрх чөлөөг нь хязгаарлаж байдаг. Тиймээс хайртай хүн чинь үхсэн тохиолдолд харамсан гашуудахгүй байх нь хамгийн зөв. Энэ хэцүү гэдгийг би мэдэж байгаа, гэхдээ энэ нь түүнд өгч буй өргөл барьц,

хайр энэрлийн хамгийн дээд хэлбэр юм. Нэгэн сүнс энэ “Шорон” болсон биенээс, физик түвшний хязгаараас чөлөөлөгдэн олон зүйлийг сурч, хийх дуртай олон зүйлээ хийх боломжтой болж байгаад нь бид харин баярлах ёстой. Бид нас нөгцж буй найз, хамаатныхаа дараах амьдралыг харж чадахгүй учраас л тэдний үхэлд баясаж чаддаггүй юм. Бид үхсэний дараах амьдралыг маш шинжлэх ухаанч, логик аргаар харахыг сурах боломжтой.

Бид хэрхэн үхэхийг сурч, энэ амьдралаас өөр олон гариг хэмжээсүүдийг харан, энэ төрлийнхөө дараах амьдралдаа баталгаатай, сэтгэл амар байх болно. Мөн бидний хайртай хүмүүс хаашаа одож буйг мэдэх бөгөөд энэ дэлхийг орхисныхоо дараа бид өөрийн очих газраа ч сонгож болно. Ийм замаар бид үхэхээс хэзээ ч айхгүй бөгөөд хэн нэгэн үхлээ гэхэд түүний хойноос уйлахгүй юм. Уйллаач бид тийм их гуниг зовлон, алдаж харамсан мэдрэмж, хүнд хэцүү зовлонг мэдрэхгүй. Магадгүй бид баяр жаргалаасаа л болж уйлах байхдаа.

◆ Бэлэнхийхээ дараа бидний амьдрал илүү эөрөй болдог

Бид энэ дэлхийгээс чанагши хэтийдсэн ойлголттой болох үед үүнийг Гэгээрэл гэж нэрлэдэг. Гэгээрлийн маш олон түвшин бий. Нэгэн чадварлаг Багшаас авшиг хүртэх тэрхэн агшинд бид Гэгээрэл хэмээх ойлголтын зарим нэг хэсэг болох энэ өртөнцөөс чанагши орших илүү үзэсгэлэнтэй, сүр жавхлантай өртөнцийг олж үздэг юм. Тэгээд л энэ биеийг орхин явж дахин ирэх туршлагатай болдог бөгөөд энэ нь яг л бидний үхэхтэй ижил юм. Тэгээд бид үхэл гэдэг нь хичнээн тааламжтай сайхан зүйл болохыг ойлгон энэ дэлхийд хоргodoхoo болж, ямар нэг уйтгар гунигтай, хүнд сэтгэлээ хаяж гээх болно.

Нэгөө өртөнцөөс энэ өртөнцөд эргэж ирснийхээ дараа зарим хүмүүс энэ өртөнцөд амьдрах дургүй болдог. Яагаад гэвэл тэд илүү дээр өртөнцийг олж мэдсэн юм. Гэвч зөрчилдөөнтэй нь тэд амьдралд хайртай байдаг. Тэд гуник гутран үхэхийг хүсэх биш юм. Энэ тийм биш. Учир нь, амьдрал гэдэг бол үргэлжийн үйл явц бөгөөд тэд хэзээ ч үхэхгүй гэдгээ мэддэг.

Энэ нь л хүмүүсийг илүү эерэг, урам зоригтой болгодог бөгөөд тэд цаашдаа илүү сэтгэл хангалуун, ач тустай, нийгэм болон өөртөө илүү нөлөөтэй, үр бүтээлтэй амьдралаар амьдардаг юм. Ийм л учраас бид маш олон ном зохиол дээрээс Гэгээнтнууд үргэлж л хүн төрөлхтний сайн сайхны төлөө зогсолтгүй ажилладаг гэснийг олж уншдаг. Тэд өөрсдийн амьдрал, энерги хүч, билиг оюунаа хүн төрөлхтөнд үйлчлэхийн төлөө зориулдаг юм. Ялангуяа сүнс оюуны талбарт. Есүсийн амьдралыг та нар харахгүй ю. Бид түүнийг заавал Бурханы аугаа их хүү байсан гэж хэлэх албагүй. Түүний Гэгээнтэн байсан гэдгийг мэдэхэд түүний амьдралын замналыг харахад хангалттай

юм. Тэрээр хүмүүст үнэнийг түгээхийн тулд, Бурханы тухай сануулахын тулд маш их хүнд хэцүү бэрхшээл, ядуу тарчиг байдлыг тэвчин, нэг газраас нөгөө рүү өдөр бүр явганаар явж байсан. Түүнд Үнэндээ үүнийг хийх шаардлага байгаагүй юм. Та нар санаж байгаа байх Тэрээр талхыг арвижуулан 5000 хүнийг хооллож мөн усыг дарс болгон хувиргаж байсан. Ийм хүн ядуу тарчиг байдлыг заавал тэсэж байх албагүй юм. Гэвч тэрээр хүн төрөлтөнд үйлчлэхийн тулд, Бурханы сургаал зааврыг хүмүүст сануулж Үнэнийг ойлгуулан сэхээрүүлэхийн тулд, тэднийг мунхаглал болон өвчин зовлонгоос нь аврахын тулд ийм замыг сонгосон юм. Одоо Буддагийн амьдрал руу орье. Будда Католик эсвэл Христ байгаагүй гэж хэлэх ч шаардлагагүй юм. Тэр Есүстэй яг адил Христ шашинтан байсан юм. Есус мөн Буддатай адил Буддист хүн байсан. Будда юу хийж байв? Яг л Есүстэй ижил зүйлийг хийж байсан.

Бид Буддагийн судрыг унших юм бол Будда хязгааргүй их хүчтэй байсан бөгөөд тэрээр маш өндөр байр суурьтай төрсөн гэдгийг уншин мэдэж болно. Тэрээр хааны сэнтийд запарч болох байсан боловч үүнийгээ орхин хэцүү бэрх, ядуу тарчиг байдлыг тэвчин нэг газраас нөгөө рүү Үнэнийг түгээн явахдаа даруухнаар бадар барин явдаг байж. Түүнд бүр хоол хүнс ч хэрэггүй юм. Гэхдээ тэрээр үүнийгээ агуу их энэрэл нигүүсэл, ач буянаар үйлддэг байсан.

Тэдгээр өглөг өгсөн хүмүүс хариуд нь адислалыг авдаг байсан бөгөөд ингэснээрээ мөн өгөхийн ухаан, биеэ огоорон үйлчлэхийн хуааныг сурдаг байжээ. Есүстэй ижил Түүнд хоол хүнснийхээ төлөө бадар барих эсвэл хэн нэгнийг өглөг өгүүлэх ч шаардлага байхгүй юм. Зарим нэг хүмүүс адислал, билиг ухааныг олж авдаг байсан болохоор л Тэр бадар барьж өргөл барьц авдаг байжээ. Эдгээр хүмүүсийг юу ингэж биеэ үл огоорон бусдад үйлчилдэг болгодог вэ? Үүний

учир нь, тэдгээр хүмүүс мөнхөд үргэлжлэх амьдралдаа, гэгээрлээс аз жаргалыг олж авч чадсан. Тэд мөн энэ баяр жаргалтай туршлагаа бусадтай хуваалцахыг хүсдэг юм. Яагаад гэвэл, мунхаг байх нь ямар хэцүү зовлонтой байдаг болон олон алдаа эндэгдэл, гэмт хэргүүд цөм мунхагийн хар гайгаар үүсдэг гэдгийт тэд мэддэг юм. Энэ дэлхийд гэмт хэрэгтэн гэж байхгүй. Хамгийн том гэмт хэрэгтэн бол мунхаглал юм. Хэрвээ бид амьдралын нууцыг мэдчих юм бол, амьдралыг хэрхэн хайрлахыг мэдчих юм бол, хэрвээ бид гэгээрчих юм бол бид ямар ч гэмт хэрэг үйлдэхгүй. Тиймээс л алдаа гаргаж гэмт хэрэг үйлдэж буй хэн нэгэн шүүмжлүүлж шийтгүүлэх ёсгүй. Мунхаглал л үүнд буруутай байдаг.

Тийм учраас Гэгээнтнүүд хүмүүсийг буруушаахын оронд хүмүүсийг яаж энэ мунхагийн харанхуйгаас гаргахыг, өөрсдийгөө яаж таньж мэдэх, яаж өөрсдийн энэ аугаа их билиг оюунаа ашиглахыг зааж сургадаг юм. Билиг оюунаа хэрхэн хэрэгцээтэй зүйлд зарцуулах гэх гэсэн юм л даа. Учир нь хүн бүрт эдгээр их билиг ухаан далд оршин байдаг. Үүнийг л бид Бурхны орон, их хайр, энэрэл, сүр жавхлан, ухаарал гэдэг юм. Бид энэ Бурхны орноо өөрсдийнхөө хүчин чармайлтаар эсвэл хэн нэгэн мэддэг хүнээс сурч эрж олох үед бид амьдралаас хайр, асар их сэтгэл хангалиун байдал, эерэг зүйлүүдийг мэдэрч эхэлдэг. Ийм л учраас өнгөрсний бүхий л Гэгээнтнүүд хүмүүсийг гэгээрлэд хүргэхийн тулд маш шургуу ажилласаар ирсэн. Ингэхдээ тэд маш их шүүмжлэл, үл ойлголцол, хэцүү бэрхийг амсаж заримдаа бүр бүх л амьдралаа ч золиослох хэрэгтэй болдог байв.

Есүс, Сократ мөн түүнчлэн Буддагийн нэр хүндийг нь гутаан, маш олон хүн алахыг санаархаж байсан. Гэхдээ эдгээр бүх бэрхшээлүүдийг үл хайхран бүх л Гэгээнтнүүд хүмүүсийн төлөө үргэлжлүүлж ажилласаар л байдаг. Гэгээнтнүүд бол хамгийн аугаа их Энх тайвныг тогтоогчид,

хамгийн аугаа их Улс төрчид юм. Үргэлжлэх энэ дэлхийд энх тайвныг авчирдаг. Тэд бол “Титэмгүй хаад” юм. Учир нь тэдэнд энэ дэлхийн юу ч бүр хэрэггүй юм. Есүс “Түүний хаант улс нь Диваажинд байна” гэсэн байдаг. Будда энэ дэлхий дээрх хаант улсаа огоорсон. Тэдний дотоодод аугаа их хаант улс бий. Бид түүнийг “Бурхны орон” гэж нэрлэдэг. Эхлээд Бурхны орныг хайтэгвэл бүх зүйлс чам руу ирэх болно. Энэ үнэхээр тийм юм шүү.

Бид Бурхны орны ахуй ойлголтыг олж авсныхаа дараа энэ дэлхийн юуг ч хүсэхээ больдог. Санаж байна уу? Есүсийг цөлд бясалгаж байхад нь Маяагийн хаан-Чөтгөр, Эрлэг, Сатан хүрч ирээд Түүнд “Хэрвээ надад мөргөвөл чамд З өртөнцийн хаант улсыг өгье” гэдэг.

Есүс хариуд нь “Go behind me” - гэж хэлсэн. Энэ нь “Тонил” гэсэн уг л дээ. Түүнд энэ хэрэггүй.

Нэг өртөнц байтугай гурван өртөнц ч хэрэггүй юм.

Гурван өртөнцийн хаант улсад З-р диваажин бүр багтах юм. Гэвч Есүст энэ хэрэггүй. Будда бодь модны дор 49 хоног бясалган сууж байх үед сөрөг хүчин хэмээн нэрлэгдэх зүйл Түүнийг маш

олон аргаар уруу татахыг оролдож, маш олон зүйлийг өргөл барьц болгож байсан боловч Тэр үүнийг хүсээгүй. Тэгэхээр эдгээр гэгээрсэн сүнснүүдийн хувьд хүмүүс Тэдгээрийг хаанд өргөмжлэх нь энэ дэлхийн хаан гэсэн уг биш юм. Гэвч дэлхийн хүмүүс үүнийг өөрсдийн тархиньхаа мунхаг атаяа жөтөөнийхөө харгайгаар ойлгож чаддаггүй.

Есүсийг амьд ахуйд олон улс төрчид Түүнд атаархаж байсан бөгөөд ийм л учраас тэд Түүнийг алсан юм. Тэд Түүнийг буруугаар ойлгож байсанд учир нь байгаа юм. Хэрвээ үнэхээр Есүст энэ дэлхийн юу ч бүр хэрэггүй байсныг тэд ойлгосон бол Есүсийн байр сууринаас айхгүй байх байсан.

С
Б
А
Г
Ш
И
Н
Я
Р
И
А

◆ **Бурханлиг “Үтсэн”**
холбоогдоо нээх нь

Гэгээрэл нь хэзээд чухал зүйл байдаг. Бид энэ дэлхийд оршин байхыг хүсэж байсан ч, эсвэл Бурхан болохыг хүсэхгүй байсан ч хамаагүй. Хятадад: “Эхлээд гэгээр” гэсэн үг байдаг. Энэ нь өөрийгөө боловсруул, тэгээд гэр бүлээ хайрла, дараа нь улс орноо хайрла гэсэн үг болно. Хэрвээ бид өөрсдийгөө гэгээрүүлчихвэл, үг хэлж хуралд оролцохгүйгээр энэ дэлхийнхээ амар амгаланд хувь нэмэр оруулж чадна.

Өдөр тутмын амьдралд хэрхэн өөрийгөө хөгжүүлж гэгээрүүлэх вэ? Энэ бол их энгийн. Бид өөрсдийн сахилаа чанд сахих хэрэгтэй. Хэрвээ зарим нэгийг нь алдвал дахиад л хичээ. Тусlamж чиглүүлэг авахын тулд үргэлж Бурханд, Буддаруу тэмүүлж бай. Будда гэдэг нь өнгөрсөн, одоо, ирээдүй З цагийн гэгээрсэн багш юм. Хэрвээ бид тэднээс туслаач гэж үнэн сэтгэлээсээ гүйвал тэд тусланы.

Олон хүн сүм хийдэд очиж бурханд мөргөн залбирдаг ч Тэдний хүч энери, билгүүн ухаантай нэвтрэлцэхэд хэцүү байдаг. Бидний хүсэл биелдэггүйн учир гэвэл бидний холбоо хэврэг, муу, яг л телефон утас холбогдохгүй болдогтой адилхан. Бид зөвхөн хөрш маань л сонсож чадахуйц дуу чимээг гаргаж чадахаас биш тэртээ хол байгаа хэрэгтэй хүндээ хүргэж чаддаггүй. Миний нэг найз хол байлаа ч би түүнтэй телефон утсаар яг одоо та нартай ярьж буй мэт ярьж чаддаг.

Үүнтэй адилаар, Бурхан хэдий хол Бурханы оронд байлаа ч эсвэл гэгээрсэн Багш нар Буддагийн орны хaa нэгтээ маш өндөр төвшинд байсан ч, нүдэнд харагдахгүй ч гэсэн бид нэг холболтоор л тэдэнтэй холбогдож, тэднээс тусlamж авч байдаг. Энэ холболтыг Авшиг эсвэл Баптист Жон, Есүс нарын хийж байсан жинхэнэ үйл явцаар авч чаддаг. Тиймээс амьд Их Багш чухал хэрэгтэй байдгийн учир ийм юм. Эс бөгөөс Есүс, Будда Багш

нар болон бусад олон Гэгээнтэнүүд, Хутагт хувилгаад энд ирэх шаардлагагүй байсан. Тэд бидний дуудлагыг мэддэг ч харин бид нар тэдний хариултыг хүлээн авч чадахгүй байна. Тийм болохоор, тэд Бурханы орныг эх Дэлхийтэй шууд холбож өгөхийн тулд энд ирэх хэрэгтэй болдог. Тэгээд бид дахин урт хугацаагаар орчлонгоос тусгаарлагдмал байхаа болино.

Эдгээр Гэгээнтэнүүд дэлхийд ирлээ ч тийм ч олон хүн тэдэн рүү хүрч очдоггүй нь мэдээж. Гэхдээ зарим нь л очино л доо. Огт байхгүй байснаас ядахдаа бид нийтийн телефон утасыг ашигладагтай ижилхэн. Бид хичнээн хувийн утасгүй байлаа ч нийтийн утсаар бусадтай холбоо тогтоож чаддаг. Үүний адилаар Гэгээрсэн Багшийг дагагчид, их шавь нар нийтийн шугаман холбоо шиг Бурханы орон, эх Дэлхий хоёрын хооронд нийтийн холбоо болж байдаг. Магадгүй цөөхөн хүмүүс ашигласан ч энэ бол хэрэгтэй л зүйл юм. Мэдээж их тусмаа л сайн.

Хэрвээ бид өөрийн телефон утастай байх юм бол Гэгээрсэн Багш нартай шууд, цаг үргэлж холбогдож чадна. Бидэнд хувийн телефон утас байхгүй байсан ч Есүс, Будда нар шиг Их

Багш нар Бурханлиг “Үтсыг” холбох үйлчилгээг санал болгодог юм. Тэгээд бид дахин орчлонгоос тусгаарлагдмал байхaa болино. Бид энэ телефон утсаар бусадтай холбоо барьж чадна. Тэгээд мөргөн залбирах тоолондоо хариултаа маш товч тодорхой авч байх болно. Гэвч энэ нь бидний бясалгалын түвшин, ойлголтоос шалтгаалдаг. Зарим хүний ухамсын түвшин өндөр байхад заримынх нь нам байдаг. Энэ амьдралдаа бясалгалд хэр зэрэг хандаж байгаагаас л энэ бүхэн хамаарана.

Зарим төрлийн нийтлэг өвчнүүд ч эдгэршгүй байдаг. Анаагаах ямар ч эм байхгүй, одоо шинээр гарч ирсэн өвчиний талаар би яриагүй байна. Эдгээр өвчин нь урьд насных нь амьдралтай гүн холбоотойгоос юм. Эмч нар болон

эрдэмтэд өвчний үндэсийг олохын тулд одоогийн нөхцөл байдлаас цааших буюу тэр аль эртний өнгөрсөн оршихуйд нэвтэрч чадахгүй байна. Хэрэв өвчтнүүд өөрсдийгээ гэгээрүүлж чадвал яаж эмчлэхээ мэдэх болно. Тэд өөрсдийн билиг ухаанаар эмчлэх бөгөөд яагаад ийм зүйл тохиолдох болсныг чойлгох хэмжээнд хүрдэг. Тэд үүнийг зөн совингоороо мэдэж чаддаг, эсвэл энэ нь илт тодорхой байдаг. Энэ нь мөн тэдний хэр бяслагаснаас хамаарна. Хэрэв бид нэлээн өндөрт дэвшсэн сүнснүүд бол илүү тодорхой харж чадна. Хэрэв бид эхлэн суралцагч бол мэдээж тодорхой харж чадахгүй ч зөн совингоороо мэднэ. Хэдийгээр бид жаахан мэдэх байсан ч бодит ертөнц бидэнд хязгааргүй ихээр тусалдаг.

Гэгээрсэн Багш нар хүмүүст цаг үргэлж “Гэгээрэх хэрэгтэй. Бурханы оронтой, Бурханы хүчтэй холбогдох хэрэгтэй” хэмээн онцгойлон захидал байсан. Бид энэ амьдралдаа ингэж хийж чадна. Бид “Үхэл” гэж нэрлэгдэх зовлон шаналалыг туулах хүртэлээ үхлээ үхлээх хэрэггүй. Хэрвээ бид сурахын тулд, Бурханы оронтой холбогдохын тулд үхэхийг хүлээвэл бидний суралцах зүйл маань маш хязгаарлагдмал болж тийм өндөрт хүрч чадахгүй. Хэрэв бид амьд байхдаа үхэж сурвал өндөр түвшний билиг ухаанаас суралцах боломж илүү байх болно. Бид яг л өөрийн хоббигоороо сурч буй мэт, яг нэг шинэ шинжлэх ухаан, шинэ хичээл сурч байгаа юм шиг байх болно. Бид өөрсдийн жирийн амьдрал, байр сууриа хадгалан амьдрахын хажуугаар өдөр бүр энэхүү хэт ертөнцийн шинжлэх ухаанаас суралцана.

Энэхүү шинжлэх ухааныг сурахын тулд бидэнд академийн зэрэг цол, боловсролын түвшин эсвэл ямар ч санхүүгийн байдал хэрэггүй юм. Энэ бүгд үнэ төлбөргүй. Учир нь билиг ухааныг бид өөрсдөөсөө олж авч байгаа юм. Тиймээс ямар ч жинхэнэ Их Багш нар шавиасаа хэзээч ямар нэг төлбөр авдаггүй. Яагаад гэвэл бид өөрсдийн

эрдэнэсээ дахин олж авч байгаа юм.

Хэрэв би гэрт чинь нуугдмал эрдэнэсийг хаана байгааг хэлбэл ямар нэг төлбөр авах уу? Үүний төлөө би ямар нэг төлбөр авахгүй. Учир нь эрдэнэс бол угаасаа таных. Би хаана байгааг нь мэдэх болохоор зүгээр л танд хэлж байгаа юм.

◆ *Бурханы хүч Амьд Их Багшайф дамжуулдаг*

Бурханы орон бидний дотоодод бий. Буддагийн уг дүр бидний дотоодод оршдог. Библи болон бусад судруудад үүнийг дурьдсан байдаг. Тиймээс, энэ яах аргагүй үнэн юм: “Таны дотоодод Ариун Сүнс оршиж харин таны бие Бурханы сүм дуган гэдгийг та мэдэхгүй гэж үү”

Хэрэв Ариун сүнс бидний дотоодод үнэхээр л оршдог юм бол түүнийг бидхайн олоод, юуг хийн суудаг талаар нь лавлах хэрэгтэй. Ямар учраас биднийг түнэр харанхуйд орхин хаясан, яагаад бидний залбирлыг сонсохгүй, бидний амьдралыг харгалзан сайжруулахгүй байгааг асууж, шалтгааныг нь мэдэх хэрэгтэй. Үнэн хэрэгтээ

Тэр бидэнд туслахыг машид их хүсэвч бид гүйдаггүй юм. Нэг бол гүйсан ч буруугаар хүсэлтээ тавьдаг.

Библид: “Тогш тэгвэл онгойлгоно. Гуй, тэгвэл өгнө” гэсэн байдаг. Гэвч та нар өдөр бүр сүм дуганд очиж мөргөн гүйдаг. Харин яагаад хариу нь ирэхгүй байна вэ? Мөн: “Ганцхан надаар дамжуулан та нар Эцэгт минь хүрч чадна” гэсэн. Та нар “Гуй, гэхдээ миний нэрээр гуй. Тэгвэл Бурхан чамд өгнө” гэж Есүсын хэлснийг маргжээ. Бид түүний нэрээр юм гүйдаг билүү? Энэ нь Бурханаас хүчтэй гэсэн уг мөн үү. Үгүй ээ. Энэ бол зөвхөн түүний ажил нь. Жишээлбэл: Бид ерөнхийлэгчтэй уулзахыг хүслээ гэж бодъё. Шууд яваад очиж болохгүй. Заавал нарийн бичигтэй нь ярьж эсвэл зочидтой уулзалт зохион байгуулдаг төлөөлөгчөөр энэ үгээ дамжуулна.

С
Б
А
Г
Ш
И
Й
Я
Р
И
А



Тэгвэл тэр нарийн бичиг, төлөөлөгч хоёр ерөнхийлөгчөөс илүү том гэсэн үг үү? Үгүй ээ. Энэ бол зөвхөн түүний ажил. Одоо та нар надад: "Гэхдээ би өдөр бүр Есүсээс гүйдаг. Бид Католик, бид Христ. Та харин юу хийхийг минь бүү хэл" гэж хэлэх байх.

Буддистүүд, Христүүд бүгдээрээ "Бурханы шашинтууд". Би зөвхөн Бурханы нэрийг өөр өөр орны хэл дээр л хэлдэг. Энд эхнэрээ "guerida" гэдэг бол Америкт "My wife" хятадад "Tai tai" Аулакаар "Vo toi" гэдэг. Нэг үгийг маш олон янзаар хэлж байгаа биз. Тэгэхээр өдөр бүр сүмд Есүсийн нэрээр

дамжуулан Бурханаас гүйж байхад яагаад Бурханы ивээл гэрлийг олж хардаггүй вэ? Учир нь Есүс энэ материаллаг ертөнцийг орхин явснаас юм. Эндэх түүний ажил дууссан. Есүс энэ дэлхийгээс явахдаа Тэр:

"Өөрийнхөө араас хэн нэгнийг илгээнэ" гэж амлаж байсан. Бид тэрхүү Тайтгаруулагчыг олох хэрэгтэй. Тайтгаруулагчид Есүсийн дуусгаагүй ажлыг үргэлжлүүлж байгаа юм. Есүс хэлэхдээ: "Энэдэлхийд байх хугацаандаа л энэдэлхийн гэрэл байна" гэсэн. Харин үүрд гээгүй. Тэгээд Тэр биднийг тайвшуулах, бидний хайртай хүнийг орлож чадах, ядаж л ойролцоо чадалтай, стандарттай тийм тайвшуулагчийг илгээнэ хэмээн амласан. Түүний санаа нь тэр явлаач гэсэн энэ дэлхий дээр гэрэл өгөх хүн ирнэ гэсэн үг. Түүний ирэхээс ч өмнө гэрэл өгөгсөд

байсан. Тийм болохоор зарим нь түүнээс та тэр Их Багш мөн үү гэж түүний хойд дүр мөн үү? гэж асууж байсан. Тэр үүнийг эсэргүүцээгүй. Ойлгож байна уу? Нэг л сүнс, хүч, хүн төрөлхтөнд үйлчлэхийн тулд өөр өөр биеийг авч байгаа юм. Тиймээс тэрээр: "Би биш Эцэг минь надаар дамжуулан ажиллаж байгаа юм". Тиймээс гэгээнтэн Паул: "Би амьдардаг гэхдээ би биш Христ миний дотор амьдардаг" гэсэн. Учир нь бүх л аугаа гэгээрсэн гэгээнтнүүд

Эцэгтэй нэг байдаг, Бурхантай эсвэл Бурханлиг чанартай нэг байдаг.

Тийм ч учраас бүх л гэгээрсэн Их Багш нар Будда хэмээх тодорхой нэг түвшинд хүрдэг юм. Учир нь тэд нэг л хүчийг, нэг л Билэг ухаан, чадварыгашигладаг. Хэрэв та бүхэн энэ гэгээрлийн ойлголтыг мэдье хэмээвэл

би та бүхэнд үйлчлэхдээ баяртай байх болно. Яагаад гэвэл би Есүс, Будда нарын хүн төрөлхтөнд хийж байсан ажлыг уламжлан авч үргэлжлүүлж байгаа юм. Яг л та нар өөрсдийн улс орондоо эмч, инженер, хуульчийн хувиараар үйлчилдэг шиг би танай оронд, энэ дэлхийд бүх л орчлон ертөнцөд өөрийн аргаар тусалж байна. Бид өөр өөр ажил хийдэг. Намайг магтан дуулах эсвэл миний ажил, байр сууринд гайхах хэрэггүй. Би зүгээр л нэг сургуульд өөр хичээл үзээд төгссөн. Тиймээс би таны хийдгээс өөр ажил хийж байгаа юм. Зүгээр л нэг ажил юм.



**Б
А
Г
Ш
И
Й
Н**

**Я
Р
И
А**

Билгүүн ухааны сувд Эхогийн ов мэх, башиф арга


Их Багш Чин Хай Олон Улсын 7 Өврийн дэвяанд ном айлдсан нь.

1996.05.11. Камбодж.



Эго-гоотаниар тоглохыг битгий зөвшөөр. Учир нь тэр маш олон дүрд хувилан ирж байдаг бөгөөд тэр нь бидэнд байхгүй л гэж бид боддог. Жишээлбэл: "Яагаад гэж, би Багдшаа тийм их хайртай юм чинь? Би номын ах, эгч нартаа





маш их хайртай. Тэднийхээ төлөө юу ч хийхээс буцахгүй" гэдэг. Тиймээ, та нар тэднийхээ төлөө юу ч хийхээс буцахгүй, гэхдээ зөвхөн өөрсдийнхөө хүсэж буйгаар хийнэ. Тэгээд та нар өөрсдийгөө сайн охид, сайн хөвгүүд, буянтай өглөгч хүмүүс байлгах гээд завгүй болдог. Үнэн хэрэгтээ, та нар хүмүүсийн хүссэнээр хийдэггүй учраас туслахаасаа илүү уршиг тарьчихдаг. Та нар юу ч хамаагүй хийгээд өөрсдийн өдрүүдийг тун завгүй өнгөрөөдөг болохоор, бусад сайхан харагдаж хүмүүс та нарыг зэмлэж ч чаддаггүй. Тэд та нарыг бүр буруушааж ч зүрхэлдэггүй юм. Та нар хүмүүсийн хүсэж буйгаас бусад юуг л бол юуг хийдэг. Тиймээс л Эго биднийг, бид бол сайн санаатай, ач буянтай, эгогүй гэж бодуулан хуурдаг. Гэхдээ энэ бол худлаа.

Ямар нэгэн сайн зүйл хийж байгаа нь сайхан санагддаг болохоор л хүмүүс заримдаа өглөг буяны үйлдлээр сэтгэлээ тэжээж байдаг. Тиймээс цаг үргэлж бид ямар нэгэн зүйлийг хийхдээ энэ зүйл үнэхээр хэрэгтэй эсэхийг бодож байх ёстой. Үүнтэй ижилээр, бясалгагчид бид заримдаа өөрсдийгөө бид бол сайн, өглөгч, ямарч эгогүй, өдөржин завгүй, бүхнийг хийж хүн болгон бидний завгүй байгааг харж байна гэсэн бодолдоо төөрөлдчихдөг. Гэвч энэ нь тийм ч хэрэгтэй, ач тустай биш байдаг..



Их Багш Чин Хай. Тайван. Шихү

1996.02.19

СБАГШИЙН ХОШИГНОС

Энэ бол үнэн түүх юм. Би нэгэн хүнийг мэднэ. Найз биш зүгээр л танил. Хэдэнжилийн нэмнө битүүнтэй тааралдахад тэрээр хүнтэй гэрлээгүй тухайгаа хэлж байсан юм. Би "Яагаад гэрлээгүй юм бэ?" гэж асуутал тэр "Юу л даа, надад тийм зав хараахан гарсангүй" гэв. Тиймээ, үнэхээр завгүй гэх мэтийн зүйл яриад байсан.

Тэгэхээр нь би "Тэгэхээр чи хэзээ гэрлэхээр төлөвлөж байна даа? гэв. Тэр "Мэдээж би гэрлэхийг тун их хүчч байна. Надад бас товолосон хүн байгаа" гэв. Би түүнээс "Ер нь гэрлэх шалтгаан чинь юм бэ?" гэж асуув. Тэр хэлэхдээ "Та мэдэж

байгаа шүү дээ. Гоонь явах чинь үнэхээр уйтгартай юм аа. Жишээлбэл, Өглөө босоод аяга жүүс эсвэл ямар нэгэн юм уучихаад ажил руугаа яарахдаа хурааж эсвэл угааж амжилгүй ширээн дээр орхисон шилэн аяга бүх л өдөржингөө ажиллаад орой харьж ирэхэд байсан байрандаа л байж байдаг. Хэн ч түүнийг нь хөдөлгөөгүй, цэвэрлээгүй байдаг. Түүнд энэ эмх замbaraагүй, хүйтэн хөндий угтталт нь таалагдсангүй. Энэ байдал дээрдэх болов уу гэсэндээ тэр хүнтэй гэрлэмээр санагджээ. Хэсэг хугацааны дараа би түүнийг хүнтэй гэрлэсэн гэж сонссон юм.

Би: “Өө сайн байна, Баяр хүргэе! Чи тэгээд гэрлэчихээ юу! гэтэл тэр” тиймээ, тэгсэн”

Би: “За та хоёрт энэ дэлхийн хамгийн сайн сайхныг хүсье! Би одоог хүртэл чиний ярьсан шилэн аяганы талаарх түүхийг санаж байгаа шүү. Яагаав, өглөөний цайгаа уугаад ширээн дээр орхин бүх л

өдөржингөө ажиллаад орой ирэхэд тань хэвээрээ л байж байдаг шилэн аяганы түүх юу болсон бэ? Тэр өөрчлөгдсөн үү?” гэвэл тэр хариуд нь “Өө тэгсэн, өөрчлөгдсөн. Одоо намайг харьж ирэхэд 2 аяга ширээн дээр байж байдаг болсон“ гэж хэлсэн юм. (Багш болон бүгд инээлдэв. Алга ташилт)



Монгол Сарны Гэрлийн Дор

Аннелос Анжелесийн мэдээний бүлэг

*Чиэн, Гоо үзэсгэлэн, Ач буяны
хэлбэлзэлд умбаах нь*

Лос Анжелос-д саяхны болсон хамтын бясалгалын үеээр Багш ханцуйгүй цагаан цамц, хар цоохор юбкатай гарч ирсэн. Тэрээр маш үзэсгэлэнтэй харагдаж бүх л авшигтангуудын нүдийг хужирлаж байв. Багш маань тогтсон гэргүй учраас тойрон аялахдаа өөртөө тийм ч их хувцас болон гоёл чимгийг авч явдаггүй. Ихэнхдээ хямдралт хувцасыг хүүхдийн хэмжээгээр авдаг учраас бүр ч хямд тусдаг юм. Гэсэн ч ямар ч хувцас өмссөн байсан Багш үргэлж сайхан харагддаг бөгөөд Үнэн, Ач буян, Гоо үзэсгэлэн сайн сайхны биелэл болж байдаг. Энэ нь үнэхээр Түүний хэлдгээр: “Хүмүүсийг татах зүйл бол хувцас болон бие биш харин хүнээс гарч буй хэлбэлзэл байдаг” юм. Бид бүгд Багшийн хайр болон гэрлийн соронзон талбайд умбан адислалаар бялхаж байдаг. Нэгэн авшигтны ярьснаар түүний эгч нь Багшид ихэд дуртай боловч тамхи татах, мөрийтэй тоглох муу зурслаасаа болоод Багшийг дагадаггүй. Гэсэн хэдий ч тэр эмэгтэйд Багш ихэд туслаж байгаа нь мэдрэгддэг бөгөөд Багшийн зурагтай тэмдгийг хаа

сайгүй, бүр мөрийтэй тоглохдоо хүртэл зүүдэг гэнэ. Түүний хэлснээр Багш түүнд ямар тоогоор тоглохыг хүртэл хэлсэн гэнэ. (авшигтан бясалгагч нар үүнийг сонсоод ихэд гайхацаасан юм.) Нэг удаа казинод ирсэн Аулак хадагтай түүний хажууд суун“ Чи яагаад ийм азтай байдаг юм бэ?” гэхэд “Яагаад гэвэл надад нэг Багш байдаг” гээд Багшийн зургийг үзүүлтэл тэр эмэгтэй ч гэсэн Багшийг таньдаг болох нь мэдэгдэв. Одоо Багш казинод хүртэл алдартай болжээ. Багш наргин “Ямар аймшигтай юм бэ! Казинод шавь нар маань орохгүй, намайг тэнд хэнч танихгүй болохоор миний зугаагаагаргажтоглохганцгазаргэжбодсон юмсан. Одоо ч би дуусчээ” гэв. Хүмүүс нир хийтэл инээлдэв. Багш үргэлжлүүлэн “Тэр эгч төвлөрхэд л дадлагажиж байна. Хүмүүс мөрийтэй тоглохоороо бүхий л сүнс оюун, хүч чармайлтаа тоглоомондоо хандуулдаг. Хэрвээ алдвал тэд маш ихээр сэтгэлээр унан шаналдаг. Ийм л учраас тэд маш өндөр төвлөрөлтөнд байдаг. Тэдэнд төвлөрлийн анхан шатны төвшин хэдийнээ байдаг учраас хэрвээ, оюун санааны бясалгал хийж эхэлвэл бүхий л зүйлстэй болдог. Хамаг амьтныг аврахын тулд Багш казино байтугай тамд ч орох бөгөөд Өөрийнхөө байр суурийг огтхон ч

тоолгүйгээр бүхий л “84-н мянган арга”-ыг ашигладаг юм. Тэрээр булан тохой газар гэлтгүй хaa сайгүй энэ гэрлийг түгээхийн тулд энэ бүхнийг хийдэг юм.

Яруу найргийн шоно

Дараагийн үдэш Багш жирийн хувцас өмсэн ирсэн боловч мөн л үзэсгэлэн төгөлдөр дэгжин харагдаж байв. Тэрээр хүрэлцэн ирсэн хүмүүсээс асуулт асуухыг урьж байлаа. Нэгэн театрт ажилладаг авшигтан, номын ахын ярьсанаар, түүний хамтран ажиллагсадын ихэнх нь өөр өөр ахуй ойлголтыг мэдрэхийн тулд, эсвэл гутранги байдлаасаа салахын тулд эм хэрэглэдэг болохоортэрээрих ганцаарддаг тухайгаа ярив. Багш түүнд “Чи тэнд гэрэл нь байх хэрэгтэй. Бурхан чамайг харанхуйг нэвт гийгүүлэг гэж тэнд байлгаж байгаа юм. Тэгэхээр чи тэдгээр урлагийн хүмүүсийг илүү эрхэм дээд зүйл рүү чиглүүлж авч явах ёстой” гэж урамшуулав. Багшийн үгийг сонсоод тэр авшигтны сэтгэл нь ихэд хөдөлж нулимын унагаж байв. Үүний дараагаар Багш хамт бясалгагчиддаа, гэр бүлийн гишүүдээ хүндэлж тэдэнд сайнаар хандаж байх хэрэгтэйг сануулсан. Учир нь энэ дэлхий бидэнд яаж ч хандаж байлаа гэсэн, бидэнд ямар ч хүндрэл бэрхшээл тохиолдлоо гэсэн бид гэртээ хариад гэр бүлийнхээ гишүүдийг хайрлаж, биднийг ганцаардуулахгүй, хамт байгаад нь баярлах хэрэгтэй. Гэр бүлийнхэн бол бидний амьдралын багана, тулгуур юм. Тиймээс ч бид тэднийгээ хайрлан, хүндэлж үргэлж бие биедээ туслан дэмжиж байх хэрэгтэй гэв. Асуулт хариултын хэсгийн дараа, Багш адистай хоол тараангaa хүмүүсийн санагалзсан сэтгэлийг дэвтээн дундуур нь явж байв. Эцэст нь тэрээр амрахаар хаалга руу явав. Гэвч хэн ч хаалгыг онгойлгож чадахгүй гайхаж байв. Гэтэл гэнэт хаалга онгойн шинээр авшиг авсан бясалгагч, нэртэй дуучин хэдэн хүмүүсийн хамт яаран орж ирэв.

Хоцорч ирсэн тэд Багштай уулзахын тулд замдаа Багшийг хүлээж байгаарай гэж түүнээс гүйж явсан гэнэ. Аргагүй сүүлийн минутад Бурхан тэдний чин үнэнч залбирал

хүслийг гүйцээсэн юм!. Ингээд, Багш суудалдаа эргэн суутал бүгд хязгааргүй баярлацаа. Дуучны эхнэр Багшид бэлэг барив. Багш бэлгийг нь онгойлговол энэ нь тэр дуучны хамгийн сүүлийн бичлэг нь байлаа. Үүний дараагаар лимбэчин Ноён Нгок Ной болон түүний найз хадагтай Пи Лоан нар Багшийн зарим шүлгээс Түүнд зориулан уншиж сонсгохоор болов. Ингэж унших нь маш уянгалаг сайхан байсан учир Багш нүдээ анин анхааран сонсов. Энэхүү үзүүлбэрийн дараа Багш тэдэнд адистай чихэр, жимс өгсөн юм. Ийнхүү уянгалаг сайхан, яруу найргийн уур амьсгал дунд болж өнгөрсөн энэ мартагдашгүй үдшээр хамтын бясалгал өндөрлөсөн юм.

Бүтэн сафтай шоно

Дараагийн 7 хоногуудад хэдэн мянган хүмүүс Багшийг дахин харах гэж Төв дээр ирцгээж байв. Төв болон түүний эргэн тойронд баяр баяслаар бялхан хүмүүсийн нүүрэнд инээмсэглэл тодорч байлаа. Багшийг айлчлан ирэх үед Төв дээр маш том уулзалт болдог бөгөөд хамгийн онцлог үйл явдал нь гэвэл Дэлхий тэр аяараа Диваажин болов уу гэмээр өгүүлэхийн аргагүй тийм оюунлаг дээд уур амьсалаар цэнэглэгдсэн орчинд хүн болгон баясдаг. Үдэш болоход бүгд цугларч бясалгальн танхим болон хоолплох өрөөний хоорондох задгай талбайд сууцгаан Багшийн гарч ирэх тэр гайхамшигт мөчийг баяртайгаар хүлээж байв. Хүлээсэн мөч ч ирж нижгэнэсэн алга ташилтаар Багшийг угтлаа. Бидний энэрэнгүй Багш маань холоос ирсэн хамт бясалгагч нарыг хажуудаа суулган заримтай нь ярилцсаны дараа Канадаас ирсэн нэгэн авшигтанд санхүүгийн дэмжлэг хандив өргөсөн юм. Ингээд шавь нарын асуусан асуултанд Багшигээдээм наргиантайгаар хариулж хүн болгоныг инээлгэж байв. Бид яагаад хүн болж төрсөн юм гэх мэт хийсвэр асуултыг өртөнцийн үг хэлээр тайлбарлан хүн болгон Түүний билгүүн ухаарлын үгсийг амьсгал даран сонсож байв. Танхимд цоргоноос ус дуссан ч сонсогохоор тийм чимээгүй байлаа. Багш хэлэхдээ: “Бид

Т
У
С
Г
А
С
У
Р
В
А
П
Ж
П
А
Г
А




Master has graced the Los Angeles Center several consecutive weekends. Fellow initiates feel extremely honored and are intoxicated in ineffable bliss.











ТУСГАЙ СУРВАЛЖ ПАГА

нар бүхий л орчлон дээрх ухамсрын янз бүрийн төвшиний төрөлтөнүүдтэй хамт оршдог бөгөөд ухаарсан ч, ухаараагүй ч бид энэ бүх ухамсрын түвшиндээ оршиж байдаг гэсэн үг. Өөрөөр хэлбэл бид нэгэн агшинд Будда, буг чөтгөр, сахиусан тэнгэр, хүмүүс гэх мэт болж байдаг. Бид яагаад энэ материаллаг өртөнцөд хүний биеийг олоод байгаагийн шалтгаан нь бид энэ ухамсрын түвшинрүү ирэх гэж өөрсдөө сонгосноос болсон хэрэг юм. Тиймээс ч хүн дүрдээ сайн тоглохын тулд бусад бүх сувгуудаа хаасан. Ингэж л бид орон зай болон цаг хугацааг бүтээж байдаг. Гэвч өнгөрсөн болон ирээдүйг санах чадварыг маань хаадаг. Гуань Инь бясалгалин аргаар хичээнгүйлэн бясалгаж байж гэмээнэ бид мөнхөд орших нэгдмэл тэр зүйлийг дахин нээх юм". Энэ онцгой үдшийн цуглаан сайн дурын үзүүлбэрээр үргэлжилж маш сайн бэлтгэгдсэн хөтөлбөрийн дор хүн болгон инээд хөөрөөр бялхан баясан цэнгэж байсан юм. Тоглолтын дараа хүн бүр багшийг тоглолтондоо баяртайгаар урив. Дахин дахин гүйсны эцэст Багш татгалзах аргагүй болж хэдэн Аулак поп дуунууд дуулсан юм. Тэгээд Багшийг сандлаа электрон хөгжим руу аваачихад хүн бүхэн Түүнийг тойрон хамтдаа дуулцгаав. Ингэж дуулж байхад сар зөвлөн тогтуун гэрлээрээ бүхэл шөнөжин гэрэлтүүлж энэ баяр жаргалтай үйл явдлыг илүү романтик болгож байв. Багш бүгдтэй нь хамт Аулак ардын үдэлтийн дууг дуулснаар Энэ ховор нандин цуглаан өндөрлөсөн юм. Түүнийг гарч явахад хүн болгон араас нь дагаж байв. Багшийн дэргэд байх гэсэн хүмүүсийн хүсэл хэзээ ч дуусашгүй ээ. Дараагийн өдөр цугларалт шууд л бясалгалин дараа бясалгалин танхим дотор болсон юм. Хүсэн хүлээсэн хүмүүсийн сэтгэлийг ойлгон Багш шөнө дундаас хэдэн цагийн

өмнө ирсэн бөгөөд ихэнх хүмүүс бүх л шөнөжингөө тэнд байцгаасан юм.

Өмнөх хаалган дээр Түүнийг хүлээн авч буй хүмүүсийн дундуур явахдаа Багш халуун дотноор занган хайраа илэрхийлж танхимд ороход нь бараа болж байсан хүмүүс рүү ч хандаж байсан юм. Багш хүн болгонтой мэндэлж байх үед Багшийн хажууд сууж байсан нэг эмэгтэй Багштай хэдэн үг сольсныхоо дараа уйлж, инээж байв. Бидний үзсэн дараагийн зүйл бол авшигтнуудын дээрээс адистай чихрэн бороо орж байв. Нэг ёө эмэгтэйд адистай жимс өгөхөд тэрээр баярын нулимстай инээж байлаа. Багш, шавь нарынхаа маш олон эгэл өртөнцийн асуултуудад өгөөмрөөр хариулж байсан юм. Нэг хүн байрныхаа доод давхрын хөрштэйгээ асуудалтай байгаа тухайгаа ярьж яаж шийдэх талаар Багшаас асуув. Багш тэвчээртэйгээр хэд хэдэн практик зөвлөгөө өгсөн юм. Багшийн хувийн туршлага нөгөө хүнд хөршийнхөө байр байдлыг ойлгоход тусалсан. Тэрээр мөн тухайн нөхцөл байдалд хамгийн тохирох үйлдэл, анхаарал халамж, биеэ авч явах байдлын талаар үнэтэй сургамж хэлсэн юм. Багшийн хайр дахин маш олон бясалгагчдыг Түүнтэй ойр суужхалуундотнохайрадислалыг нь хүртэх боломж олгосон. Уулзалтыг Багш сунгах байх хэмээн ихэнх хүмүүс найдаж байсан боловч цаг хугацааны хязгаарлалтаас болж Багш уулзалтыг сунгах боломжгүй байв. Хүмүүсийн сэтгэлийг дэвтээхийн тулд тэрээр эгнээнүүдийн дундуур алхан Их хайраа хүмүүст тарааж байсан юм. Үнэнч сэтгэлтэй бясалгач нарт энэ нь ямар ховор боломж байсан гэж санана? Зарим нь хэдийгээр Багшийн Их хайрыг илүү их хүсэж байсан ч энэ үнэ цэнэтэй Эрхэм дээд үдэш ингэж өндөрлөсөн юм.



Бялхаж буй аз жаргал

Бид Гуань Инь бясалгалын аргыг танилцуулах семинар хийхээр төлөвлөхдөө хажуугаар нь бас Багшийн төгс сайхан урлагийн бүтээлийг нутгийн ах, эгч нартаа үзүүлэхийг хүссэн юм. Харамсалтай нь бидэнд Багшийн уран зургийн ямар ч бүтээл байхгүй байсан учир бид яаралтай тусlamж хүслээ. Гэрээс гарсан хамт бясалгагчид маш ухаалагаар хамtran ажиллаж хэрэгцээтэй зүйлсийг маань шуудан зөөгчөөр түргэн шуурхай явуулсан юм. Илгээмжийг авах үед би маш их аз жаргалтай байв. Энэ байдлыг маань шуудан зөөгч болон хамт ирсэн хүмүүс анзаарчихав. Тэгээд надаас “Та яагаад ийм аз жаргалтай байгаа юм бэ?” гэж гайхсан байдалтай асуув. Би баяртайгаар “Яагаад гэвэл, би энэ дэлхийн хамгийн үзэсгэлэнт эмэгтэйн зурсан хамгийн сайхан зургийг хүлээн авч байна” гэж хариулсан юм. Би зургийг тэдэнд харуултал тэдний царайд гэрэл цацран жаргалтай инээмсэглэл тодорч тэр газар гэнэт аз жаргалангаар бялхав. Миний тэдэнд үзүүлсэн зураг нь үүнтэй яг давхсан “Аз жаргалаар бялхсан сэтгэл” гэсэн нэртэй байсан. Харин би сэтгэлдээ, бүх л төрөлтөн энэхүү Аз жаргалан болон Бурханы хайраар ивээгдэх болтугай гэж чимээгүйхэн залбирч байв.



Онч мэргэн цэс

*Бидний сонголт биднийг дээшилүүлж эсвэл бууруулиж байдал.
Хэрвээ бид дотооддоо тэмийэлдэж сорийн оюун бодол, санаа
зориг, ажил чйлээ илүү дээшилүүлэхийг эрмэлзэхгүй юм бол
чргээлж омно байсан тэр түвшингдоо л байх болно.*

Төгсгөлгүй хайр,

Авшигтан номын эсч

Дуусашигүй зөвлөн

С Я Р У
Н А Й Р А Г

Их Багшийн амьдрал
Эрсдлийг байнга дагуулдаг
Энэ эрхэм ажлаа
Их “новиц цуглуулагч” шиг гээд
Инээж та минь суудаг ч
Ингэж хэлсэн тань харин
Энгийн нэг наргиан биш .

Хэр хэчинээн зөвж буйг тань
Хэн ч ер нь ойлгодоггүй
Учир нь Та бидэндээ
Ухаарах боломж олгодоггүй
Эмтэрсэн зүрхийг маань эмнэж
Эвийлж биднийгээ хөгжөөх гэж
Хамаг чадлаараа зүтгэдэг
Харин Та минь одоо ч бас шаналсаар.

Багшийн минь алдар Чин Хай -Ариун Далай
Биднийгээ гэх сэтгэл нь хэмжээлшгүй хайрын далай
Шавь бидний үйлийн үр дуусашгүй зөвлөнгийн далай
Гав ганцаар үүнийг үүрэгч Та хязгааргүй энэрлийн далай.

Ачит Дээд Бурханаас үүсэлтэй
Амьд оршихуй бүхнийг
Эцэс төгсгөлгүйгээр
Энэрэн хайлрахаас өөр
Аугаа Их Багшдаа туслах
Арга бидэнд үгүй билээ.
Ай даа, бидэнд нинж хайраас өөр
Авралт зам үгүй билээ

Энэ агшинаас эхлэн магадгүй бид
Эмгэг зөвлөнг тань мэдрэх болов уу
Энэхүү хайрын маань тунг хүрт, Багш минь
Элдэв бүхнийг тань хуваалцах зөвшөөрөл гүйж
Эзэн Бурхандaa харин бид залбирья

Бурхан Абрахамыг шалгасан нь

Формаса, Шихү төв, Сума Чин Хай
1990. 06. 10 [Эх нь Хялаг хэл дээр]

Эрт цагт нэгэн гэр бүл байжээ. Өрхийн тэргүүнийг нь Абрахам гэдэг. Тэр өөрийн оюун санааны бясалгалаа сайн хийх бөгөөд Бурханы анд байв. Нэгэн өдөр Бурхан түүнд өөрийн нутгаа орхиж яв гээд “Хэрэв миний зааврыг дагаж байвал – нутгаа орхин, миний хэлснийг хий – Би чамайг олон үндэстний эцэг болгоно” гэж амлжээ. Энэ нь түүнийг Бурхан олон үндэстний эцэг болгох гэсэн утга санаатай ажээ. Бурхан бас Абрахамд, түүний гэр бүлд өнөр болгох хүү болон бусад олон хүүхдийг өгөхөө амлав. Тэр: “Чи тэнгэр дэх од шиг маш олон хүүхэдтэй болно” гэж хэлэв. Тэр үед Абрахам болон түүний эхнэр их настай хөгшин байлаа. Хэдий тэд Бурханд итгэл бишрэлтэй ч “Яаж тийм боломж байх вэ? Бид хүүхэд төрүүлэхэд хэтэрхий хөгшдөнө гэж гайхлаа. Олон жил өнгөрөв. Шөнө бүр тэнгэр дээрх оддыг хараадаа Абрахам Бурхны үгийг санаж гайхширана.

Тэр Бурхан надаар тоглосон байж магадгүй гэж бодно. Сүүлдээ Абрахам, түүний эхнэр бүрэн итгэхээ болин цөхөрчээ.

Бурхамыг огсон хүүхэд

Абрахамын эхнэр гэнэт жирэмсэн болж хүү төрүүллээ. Тэд үүнд маш их баярлаж хүүгээ Исаак хэмээн нэрлэв. Олон жилийн дараа Исаак том, өндөр, хүчтэй, сайхан хүү болжээ. Тэгээд Бурхан Абрахамыг шалгахаар шийдэн нэгэн өдөр, Бурхан Абрахамд үзэгдэж: “Абрахам, Би чамайг хамгаас хайрт ганц хүү Исаакаа Мориагийн



газар хүргэж надад өргөхийг хүсч байна” гэв. Энд, “Өргөх” гэдэг нь алах буюу тахил өргөх гэсэн утгатай. Эртний хүмүүс Бурхад болон лус савдагт ингэж тахил өргөдөг байжээ. Заримдаа тэд балчир охид, хөвгүүдээр, заримдаа үхэр, морь, гахай гэх мэтээр өргөдөг байжээ. Абрахам үүнд итгэж үл чадна. Өөрөө өөрөөсөө: “Бурхан надаар ганц хүүг минь алуулахыг үнэхээр хүслээ гэж үү? Тэр нэгэн удаа намайг олон хүүхэдтэй болгоно гэж амласан. Тэр яаж миний ганц хүүг авахыг хүснэ вэ? гэж асууна. Дотооддоо өөртэйгээ тэмцэлдэнэ. Тэрбээр амьдралынхаа турш Бурханд итгэхийг л сурсан байв. Зарим хүмүүс Бурханд 50% итгэдэг байж магадгүй, харин тэр Бурханд бүхий л зүрх сэтгэлээрээ итгэдэг. Тиймээс дараа өглөө нь мод болон шүдэнз ихийг бэлдээд хүүгийн хамт Мориаг зориллоо.

Тэдний гэрээс Мориа хүртэл 3 өдөр болдог байв. Тэд тэнд хүртэл урт замыг туулах хэрэгтэй байлаа. Тэгэж явах зуураа Абрахам улмаас улам бие нь зовж, муудаж байв. Хэдий тэр Бурханд итгэдэг ч дотооддоо тэмцэлтэй бөгөөд Мориад хүрэх мөчтэй нүүр тулах зүрх байсангүй. Тэр их шаналж байсан ч хүүдээ үл хэлнэ. Түүнээс өөр хэн ч энэ тухай мэдэхгүй байв.

Абрахам Бурханд хүүгээ огов

Тэд Мориад ойртоож ирэхэд хүү Исаак нь түүнээс: “Ааваа бид Бурханд өргөл өргөх мод болон шүдэнзийг бэлдсэн

БИБЛИЙН
ТҮҮХ

билээ, харин хурга нь хаана байгаа юм бэ?” гэж асуув. Эрт цагт хүмүүс хурга хядан Бурханд өргөл өргөхөөр шатаадаг байжээ. Тиймээс Исаак Абрахамаас хурга хаана байгаа болон, зөвхөн мод, шүдэнз бэлдсэнийг асуужээ. Тэр үед аав нь санаа алдан: “Санаа зоволтгүй. Бурхан өөрөө хургыг өгөх болно” гэж хариулав.

Мориад хүрсний дараа тахилын ширээ засаж модыг цэгцтэй өрөв. Тэгээд Абрахам хүүгээ өргөхөөр бэлдэж түүний гар, хөлийг уяж зассан шүүгээн дээр байрлуулав. Тэр Исаакт: “Чи Бурханд өргөх хурга билээ. Яагаад гэвэл Бурхан чамайг авахыг хүсч байна” гэж хэлэв. Тэгээд хүүгээ алахаар хутгаа гаргав. Тэр мөчид Абрахамд Бурхан түүний нэрийг дуудан: “Абрахам, түүнийг битгий ал. Одоо би чамайг надад үнэнхүү бат итгэлтэйг мэдэж авлаа. Энэ зөвхөн шалгуур байсан юм. Одоо би чамайг миний зааврыг дагахад юугаа ч өгөхөд бэлэн байгааг чинь мэдлээ. Хүүгээ алах хэрэггүй. Хурга ойрхон байгаа. Чи түүнийг надад өргөж болно” гэж хэлэв. Тэр хургыг Бурхан бүтээсэн байлаа. Бурхан үнэхээр өөртөө нэгийг бүтээжээ.

Тиймээс энэ нь жинхэнэ хурга биш байв. Абрахам, түүний хүү хоёр их баярлаж, Бурханд талархлаа илэрхийллээ. Түүнээс хойш Бурхны Абрахамд амласан бүх зүйлс бүтсэн байна.

Абрахам үеэс үеэд олон үр удам, хойч үетэй болсон.

Үлгэр ингэж дуусдаг.

Та нар Абрахамыг сайн эцэг гэж бодож байна уу? (үзэгчид: тийм). Бурханд ингэж итгэх нь маш сайн байсан юм. Бурхан бүх зүйлийг бүтээсэн, хэрэв Бурхан тэднийг буцаагаад авахыг хүсвэл бид Түүнд буцаагаад өгөх хэрэгтэй, тэд Түүнд угаас харьяалагддаг.

Абрахам болон түүний эхнэр их хөгшин байсан ба хүүхдтэй болох итгэлгүй байсан, гэтэл тэд эцэст нь хүүхдтэй болсон. Ямар гайхамшигтай зүйл вэ энэ чинь! Хүүхдийг Бурхан өгсөн. Тэр Бурханаас ирсэн, яагаад Бурхан луу буцааж болохгүй гэж? Тийм биз дээ? (Үзэгчид: тийм).

Жомаанд хүлэгдэхгүй байх сургаал

Яагаад бидний ихэнх нь зовж байна вэ? Яагаад гэвэл бид аливаа зүйлээс салж хагацахыг үзэн яддаг. Уранхай цоорхой гутлаасаа хүртэл салдаггүй, бас хөвгүүдээ эрийн цээнд хүрсэн атал орхиж чаддаггүй. Тэрчлэн бид хайртаасаа эсвэл гэр бүлээсээ хагацвал их зовлонд унаж гунихардаг. Энэ нь бид эрт орой хэзээ нэгэн цагт нас нөгчиж, хэн ч үүрд амьдарч чадахгүйг бид ойлгохгүй байгаагаас юм. Бид нэгэн хүнд үнэн голоосоо хайртай байлаа, тэр тэгээд маргааш үхчихвэл бид хайрынхаа төлөө үхэх үү? (Үзэгчид: үгүй) Мэдээж үгүй! Бид үргэлжлэн амьдрах хэрэгтэй.

Эртний хайр дурлалын үрлгэрүүдийн дунд Лиан Шамбо, Жү Ентэй гэсэн нэгэн хосын тухай гардаг. (“Эрвээхэй янагууд” гэсэн нэрээр танил). Үүнд тэд хүн төрөлдөө 7 удаа төрж, төрөл бүрдээ гэрлэхийг хүсч байсан боловч үргэлж саадтай байлаа. Сүүлчийн төрөлдөө хамт байж саад тохиолдоогүй ч тэдний нэг нь эхлээд нас барж, нөгөө нь гүн хямралаас болон өвчилж удахгүй бас өнгөрчээ. Тэгээд тэр хоёр эрвээхэйнд хувилж тэдний хооронд байгаа саад бэрхшээлийг даван туулах гэж эрвээхэй болжээ. Энэ бол маш хэцүү нөхцөл байдал.

Бид хэрэв ямар нэгэн зүйлд хорогдвол бидний сүнс сэвтэж, бидний эрх чөлөө хязгаарлагддаг. Эрвээхэй болж хувирах нь санаа зовох юмгүй харагдavч бидний хэд нь хүн төрлийг болж эрвээхэй болоход дурлах вэ? Эдгээр эрвээхэй болсон хоёр бол өөрсдийн хайрандаа дэндүү хорогдсон учраас юм. Тэр хоёр хоёулаа сэтгэлийн маш их хүчтэй, тиймээс хоёр биендээ хорогдон, үнэнч байж эрвээхэй болцгоосон байна. Тэд бие биендээ маш их хайртай байсан учир Бурхан тэдэнд дэндүү хэрцгийг байж чадсангүй, яагаад гэвэл дахин тэд хүн болж төрвөл тэд эргэлзээгүй зовж, саадтай учрах байлаа. Тэд хамтдаа хүн болох тавилангүй байв.

Ийм төрлийн үлгэрүүдэд бие биендээ өр тавьсан эсвэл бие биенийхээ эсрэг зөрчилдөөнтэй байсан бол бие биентэйгээ нийлдэг гэж, харин саад төвөггүй харьцаатай байдаг хоёр бие биендээ тийм их дуртай байдаггүй юм. Өөрийн хамрын өмнө буй хүнд сайн байхгүй харин уулсын цаана алсад буй хэн нэгнийг хайлрадаг. Муу харьцаатай байх тусам илүү бие биендээ сайн байна. Энэ бол хүмүүсийн чанар. Хүмүүс төвөгтэй зүйлсд буюу тутаан, тэмцэлээр олж авсан зүйлдээ дуртай байдаг. Тэгээд зөвхөн эдгээр зүйлсээ үнэ цэнэтэй гэж үзнэ. Дэлхий яагаад зовлонгоор дүүрэн байдгийн шалтгаан нь хүмүүс ерөөс зовлон шаналал байхгүй гэдэгийг ойлгодоггүйд байгаа юм. Бид хэрэв өөрийн амьдралаа хүртэл алдахад хүрвэл гуниглах хэрэггүй, бусад хүмүүс бас алдахад үймүүлж саад болох хэрэггүй.

Бид амьдралаас амьдралд олон үр хүүхдтэй байсан. Бид бас амьдралаас амьдралд олон эхнэр, нөхөртэй байсан. Хэрэв байхгүй бол Бурхан бидэнд хэн нэгнийг бэлддэг.

Та нар дэлхий дээрх хүн ам удаан хугацааны турш эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн тоогоор тэнцвэртэй байгааг харж болно. Эрэгтэй хүмүүсээс эмэгтэйчүүд олон гэж бүү бод. Үгүй энэ буруу юм. Энэ газар олон эмэгтэйчүүд, тэнд арай бага эмэгтэйчүүд байж болох юм, гэхдээ дэлхий дээрх нийт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тоо нь тэнцвэртэй юм. Жишээ нь: нэгэн улсад арай их эмэгтэйчүүд байхад нөгөө улсад арай их эрэгтэйчүүд байх жишээтэй. Тэд бие биенийгээ олчихвол тэгээд асуудал үгүй болно. Гэвч дэлхийн хүмүүс бие биенийгээ олж чаддаггүйд асуудлууд гарч ирдэг. Энэ нь Бурхан бидэнд хэрэгтэй зүйлсийг өгөхгүй байгаа юм биш.

Дайны жилүүдэд олон эрчүүд амиа алдсан гэдэг боловч тэр үед эмэгтэйчүүд хэл хүнд болохдоо олон хөвгүүн төрүүлсэн билээ. Энэ үнэн биш гэж үү? (Үзэгчид: тийм). Энэ бол урт хугацааны судалгаанаас гарсан статик дүгнэлт юм.

Энэ нь Бурханы хэн ч нэгэн амьдралдаа нэгээс илүү эхнэр/нөхөртэй байж эс болно гэсэн Бурханы дүрэмтэй холбоотой юм. Учир нь чи хоёртой бол хэн нэгэнд өр байхгүй байна. Өөрөөр хэлбэл чи энэ насандаа хэт шуналтай байж хоёр эхнэр эсвэл нөхөртэй байх юм бол дараагийн амьдралдаа магад өр эхнэр/нөхөртэй байх болно, учир нь чи нөхөн төлөх ёстой. Тэрчлэн Бурхан бас айлдахдаа хүн бүр зөвхөн нэг л эхнэр/нөхөртэй байж чадна гэжээ. Лиан Шанбо болон Жү Ентэй нар урьдын төрлүүддээ тус бүр хоёр эсвэл гурван эхнэр/нөхөртэй байсан байж магадгүй. Шалтгаан үр дагаварын хуулийн дагуу дараагийн төрлүүддээ тэд эхнэр/нөхөр болж чадсангүй ба хамгаас хайртай хүнтэйгээ ч гэрлэж эс чадав. Энэ нь шалтгаан үр дагаварын хуулийн улмаас юм. Хэрэв тэд энэхүү шийтгэлээс зугтахыг хүсвэл амьд биетэй өөр төрлийг олох хэргэтэй байв. Тэгээд энэхүү цээрлэлээс суллагдахыг маш их хүсээд эрвээхэйнүүд болцгоосон байна.

Тэнивэртэй амьдралыг бидэнд олгодог

Сахил нь бидэнд тэнцвэртэй амьдралаар амьдрах боломжийг өгөхөд зориулагдсан бөгөөд энэ насандаа юм болгоноос хэт их дараа насандаа хэт бага юмтай байлгах биш юм. Энэ нь идэх болон мөнгө үрэхэд хамаарах юм. Аливаазүйлийг бүхүүхэтрүүлэн хэрэглэ, учир нь чи маргааш түүгээр дутаж магадгүй. Бид юуг л хэрэглэнэ, тэр бүхнээ зөвхөн хэмжээнд нь тааруулж хэрэглэх хэрэгтэй. Үүнтэй адил, сахилууд нь Инь болон Янь-ийн бидэнд тэнцвэртэй болгох боломжийг олгодог. Тэд биднийг зовлонгоос хамгаалахад зориулагдсан бөгөөд шахаж хавчих, цээрлэж номхотгох гэсэн биш юм.

Адам болон Евагийн тухай та нарт уншиж өгсөн эхний үлгэрт Бурхан яагаад тэднээс алимыг нуудаг вэ? Яагаад

Б
И
Б
И
Н

Т
У
Х

гэвэл тэд аль хэдийнээ хэт их зүйлстэй байсан. Ээдэн цэцэрлэгийг бүхэлд нь тэдэнд өгсөн байлаа. Юмсын бүх төрөл зүйл байдаг Ээдний цэцэрлэг диваажинд харьяалагдана. Адам, Ева хоёр ажиллах ёсвэл аливаа зүйлийг хайх хэрэггүй байв. Тэдэнд бүх юмнаас хангалттай их байв. Харин ганц алимыг идэх нь тэднийг маш их зовлонд унагасан.

Хэрвээ бидний энэ өвөг тэр алимыг идээгүй байсан бол, өнөөдөр бид магадгүй ингэж зовох ёсгүй байсан байх. Тэд хэрэв алимыг идээгүй байсан бол, тэд цэвэр ариун байж, сайн ба мууг мэдэхгүй буюу ялгаварлах үзэлгүй байх байв.

Б И Б П И Н Тэд Бурхантай адил болохыг хүссэн. Би Бурхантай адил болохын сайн талыг нь мэдэхгүй юм. Бурхныг өрөвдмөөр хүн гэж болох уу? Миний бодлоор Тэр тийм, учир нь Тэр бүхнийг бүтээж, бүх гариг ертөнц, бүх хүмүүс, хамаг амьтдыг асран тэтгэх ёстой. Тэр лав ядардаг. Эдгээр Бурхан болохыг хүсэгчид нь гарцаагүй хамгийн тэнэг.

Тиймээс бита нарт Бурхан болох хэрэггүй гэж зөвлөе. Будда болсны хэрэггүй, та нар аз жаргалтай, амар амгалан байгаа бол алтан дунджаар амьдарч, энгийн бодол санаагаар амьдар. Яагаад та нар мөнхийн аз жаргалд залбирах ёстой вэ, юуны төлөө? Будын юманд шунах тусам илүү зовно.

Аливаа зүйлд санан тэмүүлэх нь өвтгөмөөр байдаг учир нь бид байхгүй зүйлдээ шунадаг. Хадий их шунана, төдий их зовиурыг бид мэдэрнэ.

Лианг Шанбо, Жү Енгтэй нарын дурлалын тухай түүхийг жишээ болгон аваад үз. Хэрэв тэд бие биетэйгээ гэрлэх тэж тэмүүлээгүй байсан бол, тэд зовохгүй байх байсан. Гэрлэхийг яагаад асуудал болгосон юм бэ? Тэд тэр цаг хугацаагаа өөр хэн нэгнийг хайхад зориулж болох байсан. Хэн нэгнийг олж чадаагүй бол гэлэн өсвэл гэлэнмаа болох нь тэдэнд дээр юм. Тэд бие биенийгээ хүсч, шунаж байснаас зовсон. Яагаад тэгтлээ шунаж дурлах вэ?

Үүнтэй адилаар, бид оюун санааны

бясалгагчид хэтэрхий их зүйлсийг гүйж болохгүй. Бид алхам алхамаар дадлагажих ёстой. Цаг хугацаа нь болоход бид үр дүнг нь амсах болно. Мэдээж бид хичээнгүй бясалгах ёстой. Гэхдээ хамгийн чухал нь чин сэтгэл. “Будда бидний зүрхэнд байна”. Хэрвээ бид чин сэтгэлтэй байвал, Тэр гарч ирнэ. Хэрвээ бид Бурханы тусын тулд бүхнийг хийн оюун санааны бясалгалаар явбал бид эцэст нь Түүнийг таньж түүнтэй нэг болох юм.

Гурван төрлийн бясалгаг

Гурван төрлийн оюун санааны бясалгагч байдаг. Эхний төрөл нь Бурханд итгэдэг, Бурхны үгийг дагагч, Хоёр дахь төрөл нь Бурхны төлөө ажилдаг, Гурав дахь төрөл буюу хамгийн өндөр нь Бурхантай нэг байдаг. Эдгээр Бурхантай нэг буюу Бурхан болсон хүмүүс нь энэхүү байдлыг аяндаа олж авдаг, хүсэн хүлээнсээс биш юм. Мэдээж тэд чин сэтгэлтэй, гэхдээ ямар нэгэн зүйл хүсэн хүлээн горьддоггүй. Чин сэтгэл нь горьдлогоос өөр юм. Энэ хоёрын ялгааг яаж тайлбарлаж өгөхөө мэдэхгүй байна. Гэхдээ энэ нь аяндаа ирдэг юм. Үүнийг үгээр тайлбарлахад хэцүү. Заримдаа бид будилж магадгүй бөгөөд горьдлогыг чин сэтгэл гэж бодно, гэхдээ тэд үнэндээ ялгаатай. Эхний төрлийн бясалгагчид Бурхныг шүтдэг, Бурхны үгийг дагах дуртай бөгөөд үүндээ сэтгэл хангалаун байдаг. Тэд Бурхныг өдөр бүр бишрэн шүтэж тэднээс илүү өндөр хэн нэгэн Бурхан байдаг ба өөрсдийг нь халамжилж байдаг гэж бодохдоо тэд өдөр бүр Бурхандаа залбирч чадаж байвал аз жаргалтай байж бусад зүйлсийн талаас асууж шалгаадаггүй. Энэ бол эхний төрөл.

Хоёрдахь төрлийн оюун санааны бясалгагчид нь Бурхныг таньдаг, тийм болохоор Бурхны төлөө ажиллах дуртай. Тэдний хийсэн болгон нь Бурхны төлөө байдаг юм. Тэд хэсэг ажилласныхаа дараа өөрсдийн ажилдаа Бурхнаас ч илүү дуртай

болдог. Тиймээс тэд хийх өшөө олон ажлуудыг олж эхэлдэг ба Бурхны төлөө ажиллаж байгаа гэсэн зорилгоо умартаж мартдаг. Ийм төрлийн оюун санааны бясалгагчид нь маш их гавьяя зүтгэл/буян хурааж чадна. Тэд хамаг амьтныг гэтэлгэх олон сайн үйлсийг бүтээж чадна, жишээ нь: лекцтиваих, сүм хийд барих, гэлэн, гэлэнмаа болох гэх мэт. Тэднийг удаан хугацаагаар ингэж ажилласны дараа хүмүүс тэднийг шүтэн, дээдлэн хүндэтгэж магадгүй бөгөөд тэднийг сайн санаатай гэж боддог. Хүмүүс тэднийг магтсаар байна байх. Хүмүүс тэднийг магтах тусам, тэд өөрсдийн ажилдаа улам өөхшинө. Аажмаар тэд сайн үйлс бүтээх үйлсэд уягдаж эндээсээ хойш Бурхантай нэг болох боломжгүй бодог.

Энэ хоёр төлийн оюун санааны бясалгагчид нь хамгийн өндөр түвшинд хүрч чадахгүй, яагаад гэвэл нэг нь Бурханыг шүтэхэд, нөгөө нь Бурханы таалалд нийцүүлэхийн тулд ажиллан хүлэгддэг байна.

Гуравдахь төрлийн оюун санааны бясалгагч нь Бурханыг бас биширч, түүний таалалд нийцүүлэн сайн үйлс хийх боловч эдгээр нь бол хоёрдогч зүйл гэдгийг тэд мэддэг. Тэдэнд хамгийн сонирхолтой нь “Бурхан гэж хэн бэ?” Тэд зөвхөн Бурханыг шүтэж, Түүний төлөө таалалд нийцүүлэн ажиллахыг хүсдэггүй, тэд харин Бурхантай уулзахын тулд түүнийг мэдэхийг бас хүснэ. Ийм төрлийн оюун санааны бясалгагчид нь эцсийн эцэст Бурхантай нэг болох юм. Гэхдээ энэ түвшинд маш цөөхөн хүн хүрч чадна. Үүний талаар ярих нь амархан, харин ойлгох ухамсарлахад хэцүү.

Бид өдөр бүр бясалгалдаа юу олж үзэх нь манай дотоод чанарыг зааж байдаг. Хэрэв бид гэрэл харвал, бид өөрсдийгөө гэрэл байна гэж мэднэ. Хэрэв харанхуйг харвал манай дотоод чанар одоо хүртэл харанхуй дунд байна гэдгийг мэдэж авна. Тэгсэн ч бид өөрсдийн оюун санааны бясалгалаа ганц өдөр ч зогсоож үл болно. Бид оролдлогоо хэвээр хадгалах ёстой, энэ нь яг бид өдөр бүр идэж уух ёстойтой адил ба бид нэг өдрөөр идэхээ зогсоож

чаддаггүйтэй ижил юм. Яахав ганц өдөр идэхгүй байхад зүгээр байж магадгүй, харин олон өдрөөр чадахгүй.

Ийм зүйл оюун санааны бясалгаль хамаарна.

Бид цагаан хоолтон байж, өдөр бүр 2 цаг хагас бясалгах нь уйтгартай гэж бодож байж магадгүй. Гэхдээ бид өдөр бүр иддэг, харин яагаад идэхээс ядраагүй юм бол? Хоол өдөр бүр ижил байхад бид одоо болтол идсээр л байна, яагаад гэвэл манай бие махбод өсөх хэрэгтэй, манай эд эс тэжээгдэх хэрэгтэй байгаа учраас юм. Үүнтэй адилаар өдөр бүр бид 2 цаг хагас бясалгадаг, өдөр бүр ижил ингэж хийдэ, яагаад гэвэл манай сүнсэнд хөгжихөд энэ хэрэгтэй юм. Оюун санааны бясалгал нь хэцүү төвөгтэй, оюун санааны бясалгал хийхийн тулд энэ гаралт өнөөдөр сэтгэлийн илэрхийллэл, маргааш толгойгоо сэтгэлийн илэрхийллэл, өөр нэгэн хоолыг нөгөөдөр сэтгэлийн илэрхийллэл болгох ёстой гэж битгий бодоорой. Үгүй, та нар тэгэх хэрэггүй. Жишээ нь: Бидний хоол энгийн байвал хангалттай. Илүү нарийн тансаг хоол байх тусам бид өөрсдөдөө илүү яршиг удна, учир нь идэхийн зорилго нь өөрсдийн биеэ л тэжээх явдал юм. Илүү нарийн боловсронгуй хоол идэх тусам илүү хүнд үйл үр үүрдэг. Түүнээс гадна боловсронгуй хоол нь үнэхээр сайхан эд биш байж магад. Манай энэ гэдэс аягуй бол түүнийг хүлээж авч чадахгүй. Тэгээд бид боловсруулж чадахгүй өвдөх болно. Бид хайртай зүйлээсээ салж хагацах ёстой хүнд хэцүү байдалд орох үедээ гунихарч болохгүй. Оронд нь бид “Би үүнгүйгээр үхэх үү?” эсвэл “Үүнээс дээр байж болох орлох зүйл бий юу?” гэж бодох хэрэгтэй. Үнэндээ байдаг юм. Заримдаа бид бидэнтэй хамт байгаа хүнийг хамгийн мундаг, сайн хүн гэж боддог, харин түүнийг яваад өгсний дараа бид эцэст нь харин бидэнд илүү тохирок, илүү сайн өөр хүнийг олж авдаг. Тийм биш гэж үү? Бид ямар нэгэн зүйлийг олж аваад хэрэглэж байхдаа бусад зүйлрүү харахаа мартдаг. Үнэндээ энэ нь бид илүү дээр зүйлийг хайн цагаа алдаж байснаас дээр

Б
И
Б
П
И
Н

Т
У
Y
Х

ч байсан байж магадгүй.

Үягдахгүй бол нэгэн төрлийн зүйшил

Бидэнд салж хагацаж чадахгүй ганц ч зүйл гэж үнэндээ байдаггүй. Бид аливаа зүйлд автдаг нь бидний зуршилаас, бас бид түүнд хэтэрхий хорогдсоноос болдог. Бид нэг газар зогсож байвал тэндээ л зогсоод хөдлөхийг хүсдэггүй. Бид хайсан хүнээ олж авбал түүнд автаж өөр хүнээр солихыг хүсдэггүй. Хэрэв хоёр хүн гэрлэвэл мэдээж бие биендээ үнэнч байх хэрэгтэй. Хэрэв хэн нэг нь үхэх эсвэл нэг нь нөгөөгөө хайрлахаа болих асуудал үүсвэл нөгөө хүн нь энгийн бодол санаагаа хадгалах хэрэгтэй ба тэр хүнээс эсвэл өөр зүйлээс болж өөрийгөө алдах ёсгүй. Бид уй гашууд автажаараа өөрсдийн хувь тавилангаа ихэнхдээ умартдаг. Үгүй гэж үү? (Үзэгчид: тийм). Хэрэв хэн нэгнийг алдсандаа гашуудаадаа бид магадгүй бүх бүтээл нэг юм гэдгийг, юу ч үүрд байдаггүй, бүх зүйлс нэг гаралтай гэдгийг мартаж орхидог. Бид хүний физик төрхөнд хорогдож болохгүй. Тэр хэлбэр төрх алга болоход тэр хүн нь өөр газар одон өөр нэгэн төрх хэлбэрийг олдог. Жишээ нь: бид сарнай ч юм уу, өөр нэгэн төрлийн цэцгийг их хайрлана, харин тэр хатаж гундахад гунихардаг. Бид түүнээс хагацахыг тэвчиж чадахгүй бөгөөд түүнийг үүрд оршиж байгаасай гэж хүсдэг. Хэрэв сарнай болгон үүрд өөрчлөгдхэгүй байсаар байвал хэрхэн өшөө олон сарнай ургаж чадах билээ? Өөр жишээ авч үзье, нэгэн сайхан манго жимс байна. Түүнийг идэх зүрх бидэнд байсангүй бид ийм сайхан мангог модны мөчирт үүрд дүүжлэгдэн байх ёстай гэж бодно. Тиймээс идэхгүй. Хэрэв бид идэхгүй бол түүний үр газарт унахгүй байж чадахуу. Манго жимсний мод хөгширөхөд жимс гаргахаа болино, харин бид манго жимсний өөр мод суулгах хэрэгтэй болдог, энэ нь энэ дэлхийн бусад бүх зүйлсд хамаарна.

Маргааш илүү үнэ цэнэтэй зүйл бид олж

авах боломжтой шүү дээ.

Морио алдсан нэгэн хөгшин хилчний тухай хятад ардын үлгэр байдаг. Та нар бүгдээрээ үлгэр мэддэг боловч өвчин зовлонгийн үнэ цэнийг өдийн хүртэл ойлгоогүй байдаг юм. Мэс заслыг давах эсвэл өвчлөхөд миний үйл үр маш их угаагддаг. Энэ бол үнэхээр гайхалтай! Та нар үүрд итгэхэд хэцүү гэж бодож магадгүй. Заримдаа би “Хэрэв энэ үнэхээр их гай гамшиг, зовлон болон үйл үрийг цэвэрлэж чадаж байгаа юм бол надад илүү өвдөлтийг өгөө! Гэж хэлдэг. Би үнэхээр баяртай байсан. Мэдээж би өвдөхөөрөө уйлдаг яагаад гэвэл маш их өвдөж, тэсвэрлэж чаддаггүй учраас тэр. Гэхдээ энэ нь үүнийг хүлээж авахад би аз жаргалтай биш, хүсээгүй байгаа гэсэн үг биш юм. Үгүй. Хэдий өвдөл маш их байсан ч би үүнийг хүлээж авах дуртай байсан юм. Хэрэв бид өвдвэл энэ нь үнэндээ бидний амьдралын хамгийн гайхамшигтай сайхан мөч юм. Энэ нь бидний маш их харанхуй болон хүнд үйл үрийг зайлцуулж чаддаг. Хэрвээ би амьдралдаа зовж, өвчилж, өвдөөгүй бол би тэсэж чадахгүй, би хамаг амьтны үйл үрийг шингээж чадахгүй. Хэрэв хэн нэг нь маш их буянтай байлаа гээд тийм хэмжээний үйл үрээ нэгэн зэрэг шингээж чадахгүй юм.

Би удаанаар үүнийг төллөө гэхэд хэзээ энэ нь дуусах байсан бэ? Маш их амьд биес байгаа болохоор надад удаан төлөх хангалттай цаг алга. Тийм болохоор Бурхан өөрийн гэсэн тогтолцоотой байдаг. Тэр бидэнд манай үйл үрийг угаан тусалж чадна. Бурхан бидний “хог новшийг” авахдаа ачаа тээврийн хэрэгсэл эсвэл манай ачааг зөөх хүмүүсийг илгээнгээ тусалдаг байна. Тиймээс та нар гай гамшиг эсвэл өвчин зовлонд нэрвэгдвэл бүү гомдол, харин Бурханд таларх.

Өвчин зовлонгүйгээр манай сүнсний түвшин дээшилж чадахгүй, яагаад гэвэл бид маш их үйл үртэй байна. Бид өөрсдөө үйл үргүй байлаа ч өвөг дээдсийнхээ үйл үрийг одоо болтол үүрсээр байдаг.

Наргиан

“Z (зэт) гариг” – ИЙН ТҮҮХ

Шихүүгийн мэдээний групп, Формоса

Хомын ах Лиу бол компьютерийн шинжлэх ухааны судалгааны магистрт сурч буй оюутан. Түүний лут авьяас нь мэдээллийн технологийн үйлдвэрийн анхаарлыг ихэд татаад байгаа. Тэр тэнд өргөдөл өгөн, ихэд магтуулснаас хойш бид үргэлж түүнийг тоглоом шоглоомоор “Э.Т.” гэж дууддаг болсон.

Тэр бидэнд өөрийгөө “Z гариг” – аас ирсэн гэж хэлсэн. Бид гэнэхнээр “Z” – ийг шууд л Их Багшийн Тэнгэрийн Үнэт Эдлэлийн Ирээдүйн Буддагийн коллекц дэхь гялалзсан шинжтэй холбож ойлгосон. Иймээс бидний “Z гариг” – ийн тухай сайхан төсөөлөл

замхарсан. Гэхдээ Лиу номын ах энэ гаригийн тухай дүрслэл ийм байсан юм:

“Эрт урьдын цагт ертөнцийн алсын өнцөгт “Z гариг” гэх нэгэн нууцлаг гариг байжээ. Энэ гаригийн бүх оршин суугчид нь толгойдоо “Z” хэлбэртэй антеннтай: тэд бясалгаж байхдаа нойрондоо гүн автаад байвал “Z” антенны хэмжээ улам томрон тэдний түвшинг заан илтгэнэ. Энэ нь ийм байх юм: Z Z Z Z Z (з з з з з з з з). Үүнийг олон улсын хэл хэмээн үздэг байна. Тиймээс дараагийн удаа хэн нэгний хурхирахыг сонсвол, тэдний ямар хэлээр ярьж буйг болон хаанаас ирснийг нь мэдэж болох нээ”.

Бидэнд байдаг зүйлс маань бидэнд хамгийн тохиромжтой нь

Авшигтан номын ах Вессел, Кэйп хот, Өмнөд Африк, [Эх нь Англи хэл дээр]

Бид (эсвэл би гэсэн нь дээр байх л даа) буютай гэдгээ тэр болгон ухааралгүйгээр өөрт буй зүйлсээ үнэлдэггүй. Бидэнд буй зүйлс маань үнэн хэрэгтээ яг бидэнд л тохирсон байдаг. Илүү ч үгүй, дутуу ч үгүй, яг л зөв хэмжээтэй байдаг. Аль нэг хязгаар луу тэмүүлээгүй байдаг. Түүнээс гадна, бидэнд асуудал, бэрхшээл болгонтойгоо тэмцэх хүч тэнхээ хайрласан байдгийг бид мартчихдаг. Бид амандаа бувтнаж, сэтгэл хангалаан бус, үргэлж хууртагдсан мэт сэтгэгдэлтэй амьдарцаадаг. Өөрөөр хэлбэл, өөрсдийгөө бид өрөвддөг юм. Би тийм, эсвэл өдийг хүртэл тийм бодолтой нэгэн байсан гэж хэлж болно. Саяхнаас л би өөрийнхөө хэр аз буютайг дахин ухаарлаа .



шиг нэгэнхүүтэй, маань Рикки гэдэг жирийн хүн шиг гэж л дээ яагаад гэвэл тэр шизофренигээс болж зовдог, анхаарлын догоилдол гэгдэх дислексиатай бөгөөд Эпллипси (ухаан алдаж, татдаг өвчин) -ийн хандлагатай.

Бид (би болоод мэргэжилтнүүд) өвчний шалтгааныг сайн мэдэхгүй. Сэтгэцийн эмнэлгийн эмч нар Риккигийн өвчнийг маш нарийн төвөгтэй, ойлгоход хэцүү өвчинд тооцдог. Түүний ухаан нь оюуны хомсдолтой гэж буудаг.

* ЧИН ХАИН ШЭДЭЭ

Тэр яг хүүхэд шиг цагаан цайлган сэтгэхүйтэй. Анхаарлаа ямар нэг зүйл дээр төвлөрүүлэх нь түүний хувьд бараг боломжгүй. Бодол санаа нь үргэлж хаа сайгүй тэнэж байдаг. Шөнө бараг унтахгүй, дээр нь үргэлж зурагт үзэж байдаг нь түүний байдлыг улам хүндруулдэг юм. Эдийн засгийн үүднээс товчхон хэлэхэд түүний ашиг гэж үгүй, нооль заасан хүн гэж хэлж болно. Түүний өвчнийг бид саяхан илрүүлсэн хэрэг бишээ. Ердөө ч тийм биш. Түүний хэвийн бус байдлыг төрөөд хэдэн долоо хоносны хойно анзаарсан юм. Эхнэр маань энэ асуудлыг надад даатгасан. Харин хүүгийнхээ өвчний шалтгааныг олон жил хайсан нь эмч нарын хэтэвчийг зузаалснаас өөр үр дүнд хүргээгүй билээ.

Би өөрийн уур, бухимдал гашуун сэтгэлийнхээ илрэл болгож олон янзаар эсэргүүцэл үзүүлж, харааж аashiildag байсан. Энэ нь ч гарцаагүй юм. Тэгэхдээ яахав. Надад байр суурь, эрх мэдэл, эд хөрөнгө, сайн ажил, машин бас мэдээж нөгөө мундаг Би гэх мэт үзэл миний хувьд үнэ цэнэтэй гэгдэх бүхий л зүйл байсан юм чинь.

Нэлээдхэдэнжилийнөмнөхнөхцөл байдал ийм л байлаа. Тэр үеэс хойш бүх зүйлийг би 180 градус эргүүлэх шаардлага гарсан. Минийх гэгдэх бүх зүйлийг надаас булаасан, “хүний эрх” гэгдэх зүйлийг хүртэл. Тэд, нөгөө л нэг шүүгчид, хуульчид, өмгөөлөгчид гэгдэх хүмүүс намайг цэгт нь тултал хүчиндсэн. Би тэр бүгдээс үүдэн сэтгэл зүрх нь эмтэрсэн, гашуун зовлонд автсан, ядуу тарчиг, ажилгүй залуу болон хоцорсон. Нөгөө хоёр нэн чухал гэгдэх ЭГО болон БАХАРХАЛ маань үй түмэн хэсэгт хуваагдан устав.

Яг тэр үеэр охин маань бас гэрээ орхиод явчихсан юм. Эхнэр бид хоёрын гэртээ тоглох дүр солигдчихов. Тэр одоо мөнгийг зарцуулавч “Босс” болж би хэн ч биш болов.

Би тэр үед үгээр илэрхийлэхийн

аргагүй үзэн ядалтаар дүүрэн нэгэн болж хувирав. Бүр шүүх байрны өмнө амиа ч ёгүүтгэх бодол надад орж ирэв. Миний нарийн боловсруулсан төлөвлөгөөний талаар хэн ч мэдэхгүй байлаа. Сэжиг төрүүлэхгүйн тулд сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах нийгэмлэгт байнга эмчлүүлж, хямралын эсрэг эм бэлдмэл авдаг байв. Төлөвлөгөөгөө дотроо л хадгалж байлаа. Амьдралд тохиолдох аливаа зүйл учир шалтгаантай байдаг гэдгийг мэддэг байсан ч өөрийн зовлонгоо хүлээн зөвшөөрч чадахгүй байсан юм. Тэр үед хамгийн азтай нэгэн болох юм гэж санаанд ч ороогүй. Өдөр өнгөрөх тутам төлөвлөгөөг хэрэгжүүлэх цаг ойртоор л. Товолсон өдрөөс хэд хоногийн өмнө гэр ахуйн нэгэн дэлгүүрт нэг мэдэхэд оччихсон байв. Тооцоогоо хийхээр кассанд дөхөж очтол бяцхан ногоон номноос хайр энэрэл гэрэлтсэн хоёр нүд над руу харж байхыг анзаарав. Түүнчлэн сар өдөр, утасны дугаартай, хэн нэгэн таны асуултанд хариулах болно гэж бичсэн жижиг зар бас байлаа. Номыг авч болох эсэхийг лавлахад мэдээж болно гэлээ. Гэртээ ирмэгц номоо даруй уншиж эхэлсэн. Уншсан зүйл маань надад таалагдаж их л утга учиртай мэт санагдаж байлаа. Номноос хайр энэрлийн халуун дотныг мэдэрсэн. Дэлгүүрт ажилладаг бүсгүйтэй утсаар холбогдож зар дээрх утасны дугаар мөн хаягийг хэлж өгөхийг хүссэн. Тэр эмэгтэй миний юун тухай яриад байгааг ойлгохгүй байна гэхэд би маш их гайхсан. Тэнд ямарч ном зарж байгаагүй, тэр ч байтугай намайг санаж байсан ч ном авч болох уу гэж түүнээс намайг асуугаагүй хэмээн хэлсэн. Тиймээ тэр эмэгтэй намайг санаж байсан. Тэр намайг яаж мартах вэ? Би түүнд хошигнол ярьж өгсөн шүү дээ. Харин бусад зүйлсийн талаар юу ч мэдэхгүй байв. Магадгүй би зүүдэлсэн



бололтой. Номын тухайд би түүнийг өөр хaa нэгтээгээс авсан байж болох юм. Тиймээс тэр эмэгтэй тус болж чадаагүй. Түүний зөвлөснөөр номноос хэдэн утасны дугаар олсон. Миний амьдрал тэр үеэс хойш их өөрчлөгдсөн. Туйлдаж ядарсан нуруун дээрээс минь хүнд ачааг авч хаях шиг л болж билээ.

Авшиг хүртэх цаг мөчийг хүлээсээр бас хүлээсээр тэвчээр алдарсан. Сэтгэл хөдлөж та хaa ч байсан надаас нүүр буруулахгүй гэдгийг би мэдэж байна. Намайг шавиа болгож аваач гэсэн захиаг факсаар явуулсан. Гэсэн ч хүлээх хэрэгтэй болсон. Энэ зуур миний амьдрал аажмаар өөрчлөгдсөн.

Хэдийгээр ажилгүйн улмаас нилээд хэдэн жилийн турш татвар төлөөгүй ч санамсаргүйгээр улсын татварын газраас чек хүлээж авсан нь хэдэн жилийн өмнө татвараа хэтрүүлж төлснийх байжээ. Энэ явдлаас хойш тун удалгүй Мiao Лид дөрөв хоногийн дияан болох тухай мэдээ төв дээр ирэв. Багш энэ цугларалтанд авшигтан бус хүмүүс ирэхийг зөвшөөрсөн байсан ба дияан эхлэхийн өмнө авшиг хүртээх байв. Өөрт байгаа хэсэг мөнгөө зөв зарах ямар сайхан завшаан бэ? Эхнэр маань үүнийг ойлгохгүй байсан ч надад саад хийгээгүй. Би Мiao Лид очиж авшиг хүртсэн. Яг л диваажинд очисон мэт байсан. Хайрт багштайгаа ойр байхад ийм мэдрэмж төрдөгт хэнхүнгайхахгүй бизээ. Багш маань өдөр бүр намайг адислаж байлаа. Надад хэдэн үг хэлээгүй, ядарч туйлдсан мөрөн дээр минь гар хурч адислаагүй өнгөрсөн нэг ч өдөр байгаагүй. Бидэнд юу хэрэгтэй багш маань мэдэж байдаг. Багш нэг орой ариун нэрийг бидэнтэй хамт уншсан. Тэр үед мэдэrsэн сэтгэлийн баяр хөөрийг угзэр илэрхийлэх аргагүй! Яаж уйлснаа одоо ч санахгүй юм. Юутай ч тайлбарлаж хэлэхийн аргагүй бүхэл төрлийн сэтгэл

хөдлөл, ойлголцол, хайр нигүүслээр дүүрэн байсан санагдна. Миний зөрүүд зан, итгэл үнэмшлээр дутах үе байдгийг үл тоон надад итгэсэн хэвээр, гэрлүү маань замчилж, намайг зорижкуулж, тайтгаруулж, туслаж байдаг хязгааргүй тэвчээртэй хайр энэрэлт Багштай би их азтай хүн юм. Амьдралын чухал хичээлүүдийг хэтэрхий их зовлон амсалгүйгээр сурах боломжийг багш маань олгож байдаг билээ. Түүгээр ч үл барам хүүгээрээ бахархах, надаас ч доор нөхцөлтөй эцэг эхчүүд байдгийг ухаарах завшааныг багш надад олгосон юм. Тиймээс дахин хэлэхэд: Бид (эсвэл би гэсэн нь дээр байх л даа) буянтай гэдгээ тэр болгон ухааралгүйгээр өөрт буй зүйл юмсаа үнэлдэггүй. Бидэнд буй зүйл юмс маань үнэн хэрэгтээ яг бидэнд л тохирсон байдаг. Илүү ч үгүй, дутуу ч үгүй, яг л зөв хэмжээтэй байдаг. Аль нэг хязгаарлуу тэмүүлээгүй байдаг.

Бид би үзлээ орхиж чаддаг ч болоосой. Мэдээж энэ хэцүү. Бидэнд итгэл үнэмшил дутдаг. Юуг яаж хийвэл зохихыг өөрөө мэднэ гэх буруу ойлголтоосоо болж бид зовлонд унадаг. Эцэст нь хэлэхэд энэ бол бидний л асуудал. Үүнийгээ Багшид бүү даатга!

Бид Багшаасаа илүүтэйгээр шүдний эмчид итгэдэг. Эмч амаа ангай, хөдөлж болохгүй шүү гэхэд түүнийг нь хийдэг. Тэр таныг их өвтгэж болох байтал та түүнд итэгсээр л байдаг. Өвчнийг тэвчих нь зүйн хэрэг гэж бид үздэг.

Харин Багш зовлон, өвчин шаналтыг амсаж туулахыг биднээс (гүйгаагүй) шаарддаггүй. Тэр бүх гай зовлонг биднээс авч оронд нь бие биенээ хайрлах, байх ёстой газар буюу гэрлүү маань аваачихад түүнд туслах гэх мэт хийх ёстой зүйлээ л хийхийг биднээс хүсдэг. Энэ бүхнийг даван туулах боломж олгосон Багш тандаа баярлалаа.



Чин Хайн Шэдээ

ЗӨВ ГЭСЭН ЗҮЙЛЭЭ ЗОРИГТОЙГООР ХИЙ

[Эх Газрын Хятаадын Авшигтан эзч Лэй]



Миний хувьд саяхан авшиг хүртсэн нь маш азтай хэрэг байлаа. Таныг дагаж оюун санааны бясалгал хийх болсон нь миний хувьд нэр төрийн хэрэг юм. Хүмүүс юу ч гэж байсан, бид юуг зөв гэж бодно түүнийгээ хийх хэрэгтэй. Учир нь энэ бүхэн бидний дотоод билиг ухаанаас ирж байгаа аугаа Үнэн зүйл байдаг юм. Урьд нь манайхан гэр бүлээрээ Цэвэр эх газрын (Pure Land) аргаар бясалгадаг байлаа. Аав, ээж хоёрыгоо Арьяабалын бясалгалд орж авшиг авсаныг нь нэгэн өдөр би гэнэт мэдсэн юм. Тэдэн шиг засаршгүй гэжүүд Буддистууд шашин мөргөлөө яаж ийм хурдан сольдог байнаа? гэж гайхан, энэ нь намайг ихэд цочирдуулав. Бүх л шашны удирдагчид зөв замаар явж байдаг гэдэгт итгэн Буддын барималд мөргөдөг байсан учир би аав, ээжтэйгээ хамт Гуань Инь аргаар бясалгахыг хүссэнгүй. Нэгэн удаа ээжийн надад худалдан авч өгсөн Их Багшийн сэтгүүлийгуншаад тэнд бичигдсэн бүх сургаал, айлдвэр нь миний урьд мэдэж байсантай адил юм байна гэдгийг л олж илрүүлэхийг хичээв. Тэр сэтгүүлээс Гуань Инь арга нь үнэндээ ердөө ч шинэ зүйл биш юм байна гэдгийг би сайн ойлгосон. Энэ зам бол тэс өөр шашин биш, мөн чанартаа Буддын болон Христийн шашинтай л адил байв. Гэвч эргэлзэж тээнэгэлзсэн хэвээрээ байлаа. Би үүнд ямар ч шинэ зүйл байхгүй, харин ч бүх юмны Эх нь гэдгийг мэдэж байсан ч бусад хүмүүс, нийгмээрээ хүлээн зөвшөөрдөггүй. Би өдөр нь ажиллаж орой нь сурдаг учир яаж өөртөө бясалгах цаг зав гаргах вэ? Хүмүүс намайг юу гэж бодох бол? Ийм zaluu охин байж цагаан хоолтон болбол яах бол? гэсэн энэ бүх асуулт толгой эргүүлж би санаанаасаа ухрахад хүрлээ. Нэг удаа ээж нийтийн бясалгалд явж харин би гэртээ юу ч хийлгүй хэвтэж байв. Гэтэл бүх зүйл гэнэт боллоо. Гуань Инь Бодьсадва цагаанаар гэрэлтэн надад тов тодорхой үзэгдлээ. Тэр маш тод хэмжээлшгүй гэрэлтэн харагдаж байсан болохоор би үнэхээр их догдолсон билээ.

Сүүлийн арваад жилд Цэвэр эх газрын бясалглаар бясалгахдаа би Гуань Инь Бодьсадваг хэзээ ч олж хараагүй. Гэтэл ээжийгээ нийтийн бясалгалд оролцож байх үед түүнийг харлаа! Надад бүх л зүйлс агшин зуур болж, үүр цайн гэгээрэх мэт болов. Ээж маань Их Багшийн хайр хүч хaa сайгүй оршин байдаг гэж хэлдэг байсан ч би үүнд ердөө ч итгэж байгаагүй. Гэтэл тэр өдөр их хүч хайрыг би үнэхээр мэдэрсэн юм. Харин ээж хэлэхдээ гайхах хэрэггүй, зүгээр л итгэх хэрэгтэй гэсэн. Удалгүй өөрийгөө ямар тэнэг байснаа ойлгосон юм. Намайг Үнэний зам мөрөөр явахад саад болж хойш татаж байсан тэдгээр асуудлууд үнэндээ хэцүү зүйл байгаагүй юм. Үнэнийг хайж олохын тулд Багш маань тийм сайхан гэрлэлтээсээ татгалзаж чадсан байхад би бусад хүмүүс юу гэж хэлэх бол гэхээс аиж байдаг! Надад тулгарсан асуудлыг түүнтэй хэрхэн зүйрлэх билээ. Багшид үнэн сэтгэлээсээ даатгах юм бол бүх зүйлс аяндаа сайжирдаг гэж ээж хэлж байсан учрыг би одоо л ойлголоо. Би ийм сайн ээжтэйдээ баярлаж явдаг. Тэр үнэхээр сайн ээж. Миний мэддэг байсан хэдэн зүйл байсан ч энэ нь нийгэмд төдийлөн зохицдоггүй байсан болохоор тэд миний санаанаас аяндаа алга болсон юм. Энэ бүгдийг дахин сануулан намайг урьдынхтай минь адил энгийн, эгэл даруу, хайр татам бяцхан охин болгосон хүн бол та, Их Багш минь юм. Их Багш таньдаа маш их баярлалаа. Таньд нэг зүйлийг нэмж хэлэхэд өнгөрсөн долоо хоногт ааш муутай, хамт олондоо нүд үзүүрлэгддэг нэгэн эмэгтэй урьдных нь ажлын байр түүнийг тэвчихийн аргагүй болгодог байснаа харин тэрээр манай өрөөнд шилжик ирснийхээ дараа сэтгэлийнхээ гүнд баяр баясал, амар амгаланг мэдрэх болсон тухайгаа хэлсэн юм. Энэ үнэн шүү. Түүнд юу ч гэж хэлэх билээ. Үнэндээ Багшийн зураг, сэтгүүлүүд миний ширээн дотор байдаг болохоор тасалгааны уур амьсгалыг бүлээцүүлж, тиймээс л тэр

ийм их баяр баясгаланг мэдэрсэн байх. Хэдий ийм байгаа ч би хангалттай хүч чадалтай болоогүй л байна. Заримдаа би ажлынхаа дараа гэртээ ирээд ямар ч шалтгаангүй уурлан сэтгэл гонсгор болдог. Энэ нь надад нөлөөлсөөр байгаа сөрөг уур амьсгал гэдгийг би мэднэ. Заримдаа би сөрөг хүчинд бут ниргуулсэн юм шиг санагддаг. Тэгээд эсэргүүцэхэд тийм амаргүй дэндүү хүчтэй үед, намайг сөрөг уур амьсгалаас хамгаалан адислахыг Багшдаа гүйн залбирдаг. Ийм үед надад аль болох холын хол зугтах хүсэл төрдөг ч тэр үедээ “Ямар ч нөхцөл байдал байлаа гэсэн тайвнаар хүлцэн тэвч” гэж Багшийн бидэнд хэлдгийг санан тайвширч арай дээрддэг байсан. Энэ бүхнийг орхиод явах нь амар байж болох юм. Гэвч ингэх

боломжгүй бол би өөрөө өөртөө бууж егэх ёсгүй. Зөвхөн илүү их хөдөлмөрлөж оюун санааны дадлага бясалгалаа чадахын хирээр хичээнгүйлэн хийх тутам бүхий л зүйлс таатай нааштай тал руугаа эргэх болно. Их Багш дээдийн дээд Бурхан бидний дотор оршдог болохоор Буддагийн хөрөгт мөргөх шаардлагагүй. Жинхэнэ Их Багшид залбирч байхад бүх зүйл сайнаар өөрчлөгднө гэдэгт би итгэлтэй байна. Хүн бүрт дахин сануулахад: Хүмүүс юу гэж хэлэх, бодох нь хамаагүй. Зөв гэж бодсоноо л хий. Боломжийг алдаж болохгүй. Ийм боломж өдөр бүр тохиолдоод байдаггүй юм шүү. Энэ эрин үед амьдарч Дээдийн дээд Их Багштай учирсан бид бүхэн туйлын азтай, хувьтай төрсөн хүмүүс юм. Баярлалаа ээжээ.



*Хамийн түүрүнд
Түрханыг эрж хай
Мэйвэл бусад бүх зүйл өам 疽уу
ирийн болно*

[Авшигтан эзч Хүй. Тайвань. Тайлан хот]

Ч
И
Н
Э
Н
И
Й

М
Ө
Р
Ө
Ө
Р

Арьяабалын бясалгальны аргаар бясалгаж эхэлснээс хойш би сахилуудаа сахисаар ирсэн. Бурханы адислалаар энэ жил би зөвхөн Магистрын зэрэгтэй болсноос гадна Докторын зэрэг хамгаалах шалгалтанд орж хамгийн дээд оноог авч Формоса дахь Их сургуулийн түүх нийгмийн шинжлэх ухааны докторын хөтөлбөрт багтах зөвшөөрөл авсан юм. Арьяабал номын цогцос үнэхээр хүчтэй. Би билиг ухаанаа хөгжүүлсэнээр суралцахад их хялбар болсон. Миний Магистрын зэрэг авсан бүтээл ангидаа хамгийн шилдэг нь байлаа. Түүнээс гадна ангийнханыг маань бүгдийг гайхшуулсан зүйл бол би Тайнанаас Тайпэй руу Их сургуульдаа

унаагаар ирж очин боломжоороо ажилладаг байсан мөртлөө төгсөхдөө нэгдүгээрт орсон явдал юм. Тийм өндер оноотой төгсөх нь надад амар байгаагүй. Залуухан, бас гэр бүлийн хариуцлага хүлээгээгүй ангийн залуус маань миний зорьсон зүйлдээ бүхнээ зориулж байсныг талархан хүлээн зөвшөөрсөн. Арьяабалын бясалгалаар илүү сайн төвлөрч сурсан нь надад ажил, сурлагадаа амжилт гаргах боломжиг ч буй болгосон юм. Магистрын зэргийн хөтөлбөрт багтаж орохоос өмнө би менежерийн алба хашиж маш завгүй ажилтай байсан болохоор надад шалгалтанд бэлдэх цаг зав олддоггүй байлаа. Түүнээс гадна би нэг удаа алдаа гаргаснаас олон нийтийн сониноор шүүмжлүүлж байсан билээ. Энэ бүгдээс болж элсэлтийн шалгалтанд орохдоо би гутранги байдалд орсон байсан. Даргын буруу ташаа ойлголтоос болж би мөн тушаал буурав. Харин Магистрын зэргийн хөтөлбөрт багтаж орсон тухай мэдээ, мэдэгдэх хуудас хүлээж аваад догдолсондоо бүр уйлсан гээч. Үнэндээ би өмнө нь шалгалтанд их хайхрамжгүй хандаж хөтөлбөрт орох оноо ч доогуур

байв. Энэ бүх миний гаргасан алдааг Багш мэдэж байсан болохоор надад тийм сайхан бэлэг өгсөн байх. Урьд нь элсэлтийн шалгалтууд өгч байсан ч тухай бүрд шалгалтандaa унаж байв. Гэсэн хэдий ч жинхэнээр хичээнгүйлэн суралцсаны үр дүнд миний оноо маш өндөр байсан. Ийм маягаар бид Үнэн ёсонд төвлөрөх тутам Их Багш бидний бүх юмыг зохицуулах болно. Жилийн өмнө би төгссөн. 2-р улирлын 2 сарын туршид лекцэнд суух бололцоогүй гэдгээ мэдэж байсан болохоор эхний улиралд курсынхээ ажлыг бүрэн хийж дуусгалаа. Тэгээд дараагийн улиралд суухгүй байх хүсэлтээ тэр үед гаргаж түүнээс хойш хэд хэдэн удаа хүсэлт тавьсан боловч татгалзсаар байв. Гэтэл эхний улирлын сүүлийн өдөр утсаар ярьж дахин гуйгаад үзэхийгах маань зөвлөв. Надад бүтнэгэсэн найдлага байгаагүй ч “дахин оролдоод үз “гэж түүнийг хэлэх үед нь гэнэт “Энэ чинь Багшийн зохицуулалт биш байгаа” гэсэн бодол тархинд зурсхийн орж ирэв. Тэгээд би ямар ч эргэлзээгүйгээр Диний ажил

руу яаран гүйв. Дин зөвшөөрнө гэдэгт би найдахгүй л байв. Гэтэл тэрээр тэр дороо зөвшөөрчихөв! Би бараг уйлах шахан Дин миний нулимсыг харчих вий гэхээс зовон хурдхан гадагш гарлаа. Гараад хөх тэнгэр өөд ширтэн “Энэ бүх гайхамшигт зохицуулалтанд тань баярлалаа” гэж Их Багшдаа залбирав. Би түүний заасан бясалгалаас гайхамшигийг мэдэрсэн. Ийм сайн аргыг надад заасанд нь Багшдаа талархаж буйгаа ойлгосон. Нэгэн цагт бид Бурхантай нэг л холбогдсон байхад Багшийн бидэнд өгдөг бэлгүүд үргэлж тохирсон байдаг. Багш надад тэр бэлгээ эрт өгөөгүй ч гэсэн тэр улирлын хамгийн сүүлийн өдөр өгсөн билээ. Одоо би билиг оюуны бясалгалаа хийхийн зэрэгцээ сурч, ажиллаж байна. Багш бидэнд сайхан боломжоор хангаж өгдөг. Миний хамгийн гол зорилго бол зөвхөн Бурханы эзэнт гүрэн рүү гэртээ буцаж харих гэдгээ ойлгодог. Энэ өртөнцийн зүйлс бол зүгээр л гэртээ харих замыг зугаатай болгох үүрэгтэй. Тиймээс энэ зүйлсээс болж би өөрийгөө зоргоор нь тавьж Үнэний зам мөрөөр явах замаасаа хазайхыг хүсэхгүй.



Бяшан хэрэмний цнэн түүх

(Авшигтан эгч Ханна. Индиана мүж Америк)

Намрын нэгэн нарлаг өдрийн үд дундад модод улаан, шаргал өнгөөр алаглан гэрэлтэж байв. Зун цагийн дулаан агаар хэвээрээ ч сэнгэнэсэн сэвшээ салхи нь нэн таатай. Нэгэн бага сургуулийн арын талбайд Дэн нэртэй хүү гэр рүүгээ найзуудтайгаа цуг харихаар хичээл дуусахыг хүлээж байв. Түүнийг тоглож байтал хэрэмний зулзага түүн рүү дөхөн ирлээ. Хэрэмний зулзага хөөрхөн бас жижигхэн, яг хэдхэн долоо хоногтой л байх гэмээр. Тэр Дэнээс айж эмээлгүйгээр

эртний танил шиг дөхөн очлоо. Тэрээр хэрэмний нэг хөл гэмтсэн байхыг Дэн ажиглав. Тэр хөөрхөн амьтан айсан шинжгүйтүүний өмднөөс зууран мөрөндээр нь авиран гараад Дэн ихэд гайхав. Энэ үед түүний найзууд ч ирлээ. Тэд хэрмийг түүний тэжээдэг амьтан гэж бодоцгоосонд нь Дэн баяртай байлаа. Тэр хэрмэндээ Кластер (Claster) буюу Хонхорцог гэж нэр өгөв. Гэр рүүгээ харих замдаа бяцхан хэрэмд маш таатай санагдаж байгааг, түүнийг хулгайлаагүй гэдгийг ойлгож

байх шиг Дэнд санагдав. Тэр зөвхөн хэн нэгний туслалцаа хүссэн, хаягдаж бэртсэн бяцхан амьтанд туслахыг л хүссэн билээ. Магадгүй Кластерийн гэр бүлийн бусад хэрэмнүүд түүнээс дэндүү хурдан тул санамсаргүй орхин явсан байж болох бөгөөд тэр ихэд елссөн байв. Тэгээд ч тэднийхээс зугтах шинжгүй байсан болохоор Дэнийгэрийнхэн хэрэмний зулзагад маш их хайртай болцгоолоо. Дэн болон түүний эрэгтэй дүү хоёр эртнээс амьтан тэжээхийг хүсч байсан ч тэднийхэн авшигтнууд байсан учир гэрийн амьтнаас болж маш олон асуудал гарна гэдгийг мэдэцгээн зөвшөөрдөггүй байсан юм. 2 долоо хоногийн өмнөхөн Дэн ээжээсээ нохой, муур биш юмаа гэхэд зурам тэжээх зөвшөөрөл гүйсан ч ээж нь хулганаас маш их айдаг, гэтэл зурам бол хулганы нэг төрөл учир ээжийгээ жинхэнэ цочиролд оруулах байв. Кластер түүн дээр ирсэнээр Бурхан түүний хүсэл биелэх боломж олголоо гэдгийг Дэн мэдэж байв. Кластерийг арчлахад их амар. Түүнд унтах жаахан зай, хоолноос өөр бараг юу ч хэрэггүй. Тэр маш эгдүүтэй, хөөрхөн бас арчаагүй дорой байсан нь Дэнийгэрийнхэнд эсэргүүцэх боломж олгосонгүй. Бас хамгийн сайхан нь тэр байгалаасаа цагаан хоолтон бөгөөд гол хоол нь самар. Тиймээс Дэнийгэрийнхэн Кластерт бүгд хайртай болов. Кластерийг авчирсан өдөр тэд тэр даруйдаа л нохой бөөснөөс хамгаалах хүзүүвч авч өгсөн бөгөөд нэг шөнийн дотор л бүх нохой бөөснүүд алга болжээ. Дараа өглөө нь тэр, мууранд зориулж хийлгэсэн зөвлөн, үслэг даавуу дэвссэн жижиг хайрцагтаа тухлах болов. Түүний шүд нь самар хагалах хэмжээнд хүрээгүй байсан учраас түүнд самар хагалж өгдөг байжээ. Тэр эхлээд ясгүй самар идэж байснаа дараа нь хушгаар хооллох болов. Тэгээд боргоцойт самар улмаар чавга иддэг болсон гээч! Хэрэм үргэлж иддэг самраа өөрчлөөд байхаар нь Дэнийг ээж ууттай холимог самар



авчирч түүгээр өөрөөр нь сонголт хийлгэв. Яг л муурын зулзага шиг хэрэм их цэвэрч. Тэр усанд орох дургуй харин өдөр бүр л хэлээрээ үс зүсээ цэвэрлэдэг. Гэхдээ бас муурын зулзагаас дээр зүйл ч түүнд байв. Тэр нь, бие засах болохоороо Кластер “гэр”-ийнх нь хажууд тавьсан уудаг цаас руу очдог тэгээд норгох бүрд нь түүнийг нь сольдог байлаа.

Хамгийн гайхалтай нь тэр хүмүүс дээр эсвэл цэвэрлэж болохгүй ямар нэгэн газар болон хивсийг норгодоггүй. Заримдаа гэр бүлээрээ аялан Кластерийг орхин үлдээх болоход “бие засах газрын” үйлчилгээ байхгүй тохиолдолд тэр давсгаа барьж чаддаг эсвэл зүгээрлюч уудаггүй. Энэбол яах аргагүй гайхамшиг байсан ба Багшийн илгээсэн амьтан гэдэгт Дэн итгэдэг байлаа. Тэрээр Кластерийг зовж шаналахыг нь зүгээр хараад байж чадахгүй тул Дэн түүний хойд хоёр хөлийг малын эмчид үзүүлэхийг ээжээсээ шалан гүйв. Харин малын эмч түүнийг зүгээр л нэг “зэрлэг амьтан” гээд үзэхийг зөвшөөрсөнгүй. Аз болж Багш түүнийг удалгүй бүрэн эдгээсэн бөгөөд тэр баяр хөөртэй, сэргэлэн цовоо боллоо. Удалгүй Кластер гэрийн эргэн тойронд саваагүйтэн сонирхож хүмүүний өртөнцийтэй танилцан шинэ зүйлс өөртөө нээж байв. Тэрээр шинэ гэр бүлийнхээ гишүүд рүү ямар ч эргэлзээгүй авирч тэдний өвөр дээр нь юмуу мөрөн дээр нь тухтайхан тухлан хэвтээд зүүрмэглэнэ. Зэрлэг хэрэм байхаасаа л ихэнхдээ царсны боргоцой иддэг. Хатуу хальстай самар, царс мод эргэн тойронд нь байдаг болохоор өдөр бүр тэд шүдээ хурцалдаг. Гадаа ажилладаг цэцэрлэгч түүнийг авирч дээр нь суун мэрэг гэж жижиг жижиг мөчиртэй нэгэн урт мөчир авчирч өгсөн нь түүнд дасгал хийх хэрэгсэл болдог байв. Дэнийгэрийн арын хашаанд жижигхэн ойн бус байдаг. Заримдаа Кластерийг тоглуулахаар гадаа авч гарахад гадаа байх тийм ч дуртай байсангүй. Намар өнгөрч хүйтэн салхи шуурч, цас хаялан өвлийн

С
Б
Я
Ц
Х
А
Н
А
В
Ш
И
Г
Т
Н
Ы
Б
У
Л
А
Н

хүйтэн уур амьсгал ойртох үед бяцхан Кластер гадаа гарахгүй болсондоо маш таатай байдаг болов. Түүнд жижиг агууд эсвэл хaa нэгтэй хоргodoх хэрэг байгаагүй болохоор энэ нь түүнд амар байсан байх. Тэдний ойролцоох нэгэн талбайд хэсэг мод байдаг бөгөөд тэнд хэрэмнүүд заримдаа идэх юм хайн ирдэг болохыг нь мэдээд Дэн, түүний дүү хоёр Кластерийг тэдэн рүү аваачив. Тэд Пластерийг нэг хэсэг гайхан харж байсан ч төдийлэн тоосонгүй. Хөвгүүд хөрш амьтдад хальстай самар өгөхөд тэдгээр найрсаг хэрэмнүүд бүгдийг нь амандаа хийчихээд дараа хооллохын тулд түүнийгээ булах газар хайхаар зэргэлдээх хашаа руу явцгаав. Тэд дараа нь дахин Дэнийд ирж үргэлжлүүлэн самраа идсээр сүүлчийн самар дууссан хойно л явцгаалаа. Хэрэмнүүд тийм олон хоногийн өмнө самар булсан газраа яажсанаж чадаж байгаа нь гайхалтай байв. Кластер маш ухаантай, хайр хүрмээр байдаг болохоор Дэнд заримдаа зэрлэг амьтан биш харин (хүний сүнчтэй) гэр бүлийнх нь нэг гишүүн мэт санагдана. Түүнийг үрчилж авсан гэр бүлдээ Кластер их хайртай. Тэд түүнийг тэврэн халамжлахад ихэд тааламжтай байдаг байв. Ямар нэг зочин эсвэл танихгүй хүн ойртоход тэр бяцхан “гэрийнхээ” араар нуугдах юмуу гэрийнхнийхээ хэн нэг рүү гүйн очно. Ер нь амьтдад сүns байхгүй гэж хэн хэлсэн юм бэ? Бас яагаад хүмүүс амьтдаар зугацахын тулд эсвэл идэх гэж зовоон алдаг юм бэ? Дэн амьтдыг өхөөрдөм хөөрхөн бас ухаалаг, хайр хүрэм төрөлтөнүүд гэдгийг нь мэддэг байсан. Амьтад болон хүмүүс хамтдаа эвтэй амьдраасай гэж хүсдэг байлаа. Хavar ирж хүйтний улирал урин цагаар солигдож өвс ногоо дахин зөөлөн ногоон хивс шиг


болов. Дэний ээж нэг удаа цэвэр агаар оруулах гэж хаалгаа онгойлгожээ. Энэ үед Кластер гарч гаднах ертөнцтэй танилцах дадлага хийв. Гаднах ертөнц түүнд маш үзэсгэлэнтэй, эрх чөлөөтэй бас нээлттэй байсан бизээ. Гэр бүлийнхэн нь түүнд хэдийгээр маш их хайртай ч гэсэн түүнийг байлгаад байх зорилго байхгүй, үлдэхийг хүсэхгүй бол яваг дээ гэж байлаа. Кластер тэр оройдоо буцаж ирлээ. Магадгүй, тэр явах ёстой эсэхээ бодсон байх. Маргааш нь тэр дахин гарлаа. Тэр энэ удаад ертөнцтэй бүр илүү танилцааар шийджээ. Гадаах зулэг моддиг харан үнэрлэж довжоон дээр удаан суув. “Өөх! Энд байхаас илүү гаднах амьдрал надад илүү таалагдаж байна” гэж магадгүй тэр бодсон байх. Амьдрал урьд байснаас нь ч илүү сайхан гэдгийг тэр мэдээгүй байх. Тэгээд тэр довжооноос талбайн зүг модод руу явлаа. Гайхамшигт шинэ амьдрал, адал явдлууд түүнийг хүлээж байгаа. Кластер эргэж ирсэнгүй. Дэн дүүтэйгээ түүнийг хайсан боловч гадаа зах хязгааргүй уудам болохоор магадгүй аль хэдийн хaa нэгтэй оид маш хол явсан байх. Ингэх нь ямарч ашиггүй гэдгийг мэдэж байвч тэд түүнийг их санаж байлаа. Тэд өдөр бүр л гарч харан, Кластер эргэж ирэн уулзах боловуу гэж найдсаар. Гэвч тэр хэзээ ч эргэж ирээгүй юм. Тэр үүрд явсан бөгөөд түүний бие даасан шинэ амьдрал эхэлсэн юм. Тэд Кластерийн нохой бөөснөөс хамгаалах хүзүүвч хүзүүг нь боож байгаа болов уу, хүзүүвч нь унаж түүний хүзүү хэвийн өсч том болоосой гэж санаа зовон Бурханд залбирч байв. Аз дайрч талд нь хүртэл мэrsэн түүний хүзүүвчийг олсон юм. Магадгүй, Бурхан түүнийг үргэлж харж хандаж байдаг бизээ.



Харь гаригийнхантай уулзсан нь

Бяцхан авшигтан 8 настай Бан Би. Формоса. Таюан

30 хоногийн өмнө



Холын гариг руу аялсан ер бусийн зүүд

Нэгэн орой аав надад хэтэрхий их кофе өгчихсөн юм. Би орондоо эргэж хөрвөн унтаж чадсангүй. Тэгээд “Би үнэхээр нисмээр байна” гэж бодож эхэлтэл цонхны цаана цагаан өнгийн үл мэдэгдэх нисдэг биет байхыг олж харав. Би сониуч зандаа хөтлөгдэн цонх руу очиж цаашаа үсрэн буулаа. Хөршийнхөө дээвэр дээр буутал нисдэг таваг тэнд газардсан байв. Нисдэг тавагнаас сонин жигтэй амьтад гэнэт гарч ирцгээв.

Тэдний толгой нь хулсны баавгайтай төстэй, бие нь мэлхий шиг, нүд нь толгойн орой дээрээ гар нь хүссэнээрээ сунаж агшдаг. Бас толгой дээрээ антентай, хамаргүй байлаа.

“Та нар Харь гаригийнхан мөн үү” гэж намайг хятадаар асуухад “Тиймээ, бид мөн” гэж тэд толгой дохин хариулцгаав. Надаас “манай гариг руу явцгаая” гэж хэлээд сансрын хөлөг рүүгээ авч явлаа. Тэдний гаригт хүрч очсоны дараа маш олон хачирхалтай зүйлсийг би олж харав. Жишээ нь тэндхийн мод, навчис нь бүгд доошоо харан ургадаг бөгөөд бүх зүйлс нь манай дэлхийнхээс өөр байсан.

Тэд “Чи хүссэн хугацаагаараа энд амьдарч болно” гэснээр би 30 хоног тэнд saatan дараа нь харь гаригийнханаар гэр рүүгээ хүргүүлэв. Гэртээ харихад өглөөний 3:30 болж байлаа. Тэгж л би сэтгэл амар хоцров.

Айдастуй бяцхан бодьсадва

12 настай авшигтан Чэн Вэй Тин. Формоса. Тайлэй.

Би оюун санааны бясалгалаас үүдэн өдөр тутмын амьдралдаа олон зүйл сурч байна. Тухайлбал, нэг удаа хөл минь гэмтэж мэс засал хийлгэх боллоо. Би маш их аиж байсан тэгээд төвлөрч Багшийн нэрийг давтан уншлаа. Хачирхалтай нь, долоон удаагийн мэдээ алдуулах тарилга хийлгэхэд огтхон ч өвдсөнгүй. Өөр нэг удаа шалгалтанд орох болов. Урьдынхаасаа илүү сайн хийж чадахгүй байх гэж бодон шөнөжин Багшийн нэрийг уншин түүнд залбирсан юм. Түүнээс хойш би

С
Б
Я
Ц
Х
А
Н

А
В
Ш
И
Г
Т
Н
Ы

Б
У
Л
А
Н

ангийнхаа тэргүүний сурагч болсон доо. Бас нэг тохиолдолд, миний шүд унаж өгөхгүй, их өвдөн цус гарч байлаа. Ээж маань билгийн нүдэн дээрээ төвлөрөөд бясалга гэлээ. Бясалгаад дуусахад ямар ч цус гаралгүйгээр шүд уначихсан шүү.

Үрлашийнхны тоорогдол

Их багш Чин Хай, хамтын бясалгал, Л.А, АНУ.

1997, 7-р сарын 13

A
С
У
П

Х
А
Р
И
У
П

А: Би театрт жүжигчид, бүжигчид эрэгтэй эмэгтэй жүжигчид болон хөгжимчид гээд олон урлагийн хүмүүстэй ажилладаг. Тэд өөрсдийн гутранги байдал, бухимдлаа тайлах гэж хар тамхи (Марихуан) татах гэх мэт янз бүрийн зүйлсийг байнга хийж байгаа харагддаг. Бид урлагийнхан учраас аливаад нээлттэй байхыг хүсч аль болох олон зүйлийг бие дээрээ туршиж үзэхийг хичээдэг. Гэвч би Арьяабалын аргаар бясалгадаг болохоор зарим нэг зүйлийг хийж боломгүй санагдах юм. Мэдээж, би энэ бүхнийг хийж болохгүйгээ мэднэ. Гэхдээ сайн жүжигчин больё гэвэл ямар нэг зүйлийг туршиж үзэх хэрэгтэй гэсэн онол байдаг юм л даа. Тэгээд заримдаа энэ бүхний талаар эргэлзэх үе гардаг болохоор надад таны зөвлөгөө тусламж хэрэгтэй байна.

Б: Тэдгээр хүмүүс их төөрөлдөж байна. Тэдэндамьдрал нийххосон мэт санагддаг. Олон түмний таашаалыг хүртэх гэж хамаг байдгаараа хичээсний дараа сэтгэл нь хоосорч хэнд юунд хандахаа тэд мэдэхээ байдаг. Энэ нь аргагүй юм. Тэд Буддад хандахад Будда хариулахгүй, Есүстэй ярих гэхэд тэнд Цовдлоостой. (Инээв) Тийм болохоор тэд дотоод дахь хоосролоо ямар нэг зүйлээр хурдхан нөхөх гэж оролддог. Ер нь олон нийтийг хамарсан ямар ч ажил дотоодод маань хоосролыг авчирдаг. Та нар мэдэх хэрэгтэй. Энэ бол урлагийн хүн бүрийн гаргадаг маш том золиос юм.

А: Би мэргэжлээ солих хэрэгтэй юу?

Б: Хэрэггүй. Чамд Багш, бас Арьяабалын номын цогцос байна. Бясалгал танд дотоодын амар амгалан болоод сэтгэл ханамжийг хар тамхинаас ч илүү түргэн өгнө. Тэдгээр хямд төсөр зүйлс танд ямар хэрэгтэй гэж? Та тэдгээр хүмүүсийг дагах биш харин дагуулвал таарна шүү. Та бол Гэрэл, харанхуйг дагах хэрэггүй. (Алга ташив)

А: Заримдаа тэр хүмүүсийн дунд би маш их ганцаардаж байх шиг санагддаг.

Б: Үгүй ээ, та ганцаараа биш. Та тэднийг замчилж, тэднийг адислаж, тэдэнд байхгүй зүйлийг нь өгөх гэж, мөн тэдний эрч хүч болох гэж тэнд байгаа юм. Учир нь тэд түнэр харанхуйн дунд байна. Та бол тэнд буй цорын ганц Гэрэл гэгээ, тэгсэн хирнээ өөрийгөө бөхөөж түнэр харанхуй руу орохыг хүсч байна гэж үү?! (Алга ташив)

Түнэр харанхуй дахь ганц гэрэл байг гэж Бурхан таныг томилжээ. Та тэдэнтэй ярилц. Илүү сайхан, илүү гэрэл гэгээтэй, аюул хохиролгүй, бас Эрхэм дээд зам мөр байгааг тэдэнд хэлж өгөөрэй. Тэд ганцаардаж буй учир та тэдэнд хэрэгтэй. Та хүч зоригтой байх ёстой. Талархах сэтгэлтэй яв. Урлагийн хүн байна гэдэг нь эрхэм юм. Та олон хүнд баяр баясгаланг бэлэглэж, цагийг хурдан өнгөрүүлэхэд нь тэдэнд туслаж байна.

Тэд сайхан кино үзэх бүртээ боловсорч байдаг. Театрын сайн тогтолт үзэх бүртээ боловсорч байдаг. Мэдээж өгөх тоолондоо бид хоосорч байдаг болохоор

ганцаардлыг илүү ихээр мэдэрдэг. Үзэгчдийн нижигнэсэн алга ташилтын дараа жуужигчид ганцаардлыг улам ихээр мэдэрдэг. Тэд хоосролыг мэдэрдэг. Би мэнднэ. Бүтэн сайн өдөр бүр би үүнийг мэдэрдэг. Хамтын бясалгал бүрийн дараа би үүнийг мэдэрдэг. Би ч бас хоосордог. Та нарыг сэтгэл ханамжтай, аз жаргалтай болгохын тулд буй бүхнээ би та нарт уудлан өгдөг. Урлагийн хүнийг бүү хэл, би ч хоосрол ганцаардлыг олонтоо мэдэрдэг. Гэвч би хүчтэй байх ёстой. Та ч хүчтэй байх ёстой. Бид хүчтэй байж, хүмүүст өмөг түшиг болох ёстой юм шүү. Бид бол замыг гэрэлтүүлэгч Цамхаг. Хялбар, амарчилсан замаар алхаад бүү татагд. Та уналтанд орно шүү дээ, үүндээ харамсахын сацуу олон хүнийг өөрийн хамт уруу татах болно. Та зөвхөн урлагийн хүн бишээ, та бол Гэгээнтэн. Хэлж буй зүйлс маань тус болно гэж найдъя.

Та бол Гэгээнтэн. Үүнийг сана! Жуужигчин, урлагийн хүн гэдэг гаднах багаа март. Та бол тэдгээр хүмүүсийн сэтгэл санааг өөдрөг байлгахын төлөө тэнд байгаа баг зүүсэн Гэгээнтэн байхгүй юу. Тэнгэрлиг сайхан, илүү учир утгатай зүйлсийн талаар тэдэнтэй ярилц. Тэд таныг хүлээж авахгүй байсан ч тэдний ой ухаанд нь бичигдэх болно. Өнөөг хүртэл ой ухаанд нь тэмдэглэгдэж байснаас нь илүү сайн зүйлийг тэдэнд өг. Тэдний ой ухаан өдийг хүртэл үргэлж сөрөг мэдээллийг тэмдэглэн авч байжээ. Харин одоо та түүнийг нь илүү

зэрэг мэдээллээр орлуулах хэрэгтэй. Тэд хүлээж авах эсэхээс үл хамааран ой ухаан нь таны ярьсаныг тэмдэглэж авсаар байх болно. Тэгээд хожим урган соёолж үр жимсээ өгөх нь лавтай. Та хийсэн зүйлээ юманд бүү бод. Зүгээр л хий.

Хэн нэгэнтэй яриа өрнүүлэх бүрт, эсвэл хэн нэгнийг баярлуулах бүрт, хийсэн зүйл тань маш сайн боловч таны дотроос ямар нэг зүйлийг салгаж байдаг. Тэгэх нь ойлгомжтой л доо. Харин та энэ тухай мэдэж байсан тохиолдолд буцаж нөхөгдөх л болно. Зарим хүмүүс мэддэгүй учир илүү удаан хугацаа шаардагддаг. Тэд түргэн үр дүнг хүсдэг. Тэд маш их хоосролыг мэдрээд яахаа мэдэхээ больж төөрөлдөн самгардаж, ганцаарддаг.

Тэгээд зарим нэг хүмүүс тэдэнд “Үүнийг татчихвал диваажинд очих шиг л болно” гэж хэлдэг. Уур бухимдал, сул дорой байдал, сониуч зангаасаа болж тэд түүнийг нь туршиж үздэг. Тэгээд үүнээсээ больж доош уруудан уналтанд орж босч чадахаа больдог. Үүнд л гол асуудал оршино.

Юуг ч сонирхож оролдож үзэж болно л доо, тэгэхдээ энэ бүхний эцэст амьдрал тань ямар болох бол? Тэгэхээр бид ойлгох хэрэгтэй, ямар сонголтууд хийх нь бидний эрх мэдэлд буй боловч үр дагаварууд нь өөр өөр байдаг. Бурхан та нарыг хүссэн зүйлээ туршиж үзэхийг зөвшөөрдөг. Тэгэхдээ та өөрийн гэсэн билиг ухаантай учир, ямар сонголтууд танд хэрэгтэйг мэдэж байх үүрэгтэй.



АСУУЧТАХАРИУУЛГАА

Аймшигт хар тамхи

1995 оны 7-р сарын 27

Их Багш Чин Хайн Шихү, Формосад айлдсан нь

А: Би бясалгалаа нэгэн асуудалтай тулгараад байна. Өмнө нь, хэдэн жилийн турш би нэлээд хэдэн төрлийн ухаан санаа самууруулдаг хар тамхи хэрэглэж байсан юм л даа.

Б: Тэгээд одоо яах гэж байна? Хэрэглэхгүй байгаа чинь сайн байна, чамд хэрэгтэй. Мэдээж хэрэг тархиний эд эс тань бага зэрэг гэмтэл авсан байх, тэгэхдээ зүгээрээ, үүнийг бид хамтдаа засах болно. Бясалганд тань төвөг учраад байна гэсэн. Ямар асуудлууд байгаа юм бэ?

А: Төвлөрөлийн асуудал.

Б: Төвлөрөх. Тэгэлгүй яахав тиймээс л чи бясалгах хэрэгтэй. Тэгэхдээ чи зүгээрээ, чи эмчлэгдсэн. Бүү санаа зов. Төвлөрөл гэдэг бол энэ дэлхийн хүн бүрт байдаг “өвчин” юм. Тиймээс санаагаа бүү зовоо, сэтгэлээ амраа тэгээд бясалгах бүртээ эндээ (Багш билгийн нүд рүүгээ заана) элбэрэл хайраар дуурэн чин сэтгэлтэйгээр төвлөрөөрэй. Тэгвэл дотоод тархи тань массажлагдана. Хайраа ашиглаж, дотоодтойгоо холбогд, энэ л чамд хэрэгтэй. Чи хар тамхийг тийм ч удаан хугацаагаар хэрэглээгүй болохоор зүгээрээ. Эмчилж, засч болно. Аялгууны бясалгалаараа бясалга, тэгвэл улам эмчлэгдэнэ. Энэхүү арга нь чиний тархины эд эсийг нөхөн шинэчилж шинэ амьдралын эрчим хүчээр хангана. Үүний талаар бүү санаа зов.

Улам илүү чармайлт гарган бясалгах хэрэгтэй. Төвлөрөх боломжгүй байсан ч хийх л хэрэгтэй. Гуань Гуань - Гэрэл ажин бясалгахад төвлөрөхөд мэдээж хэцүү байдаг. Харин Гуань Инь хийхэд, төвлөрөхгүй байсан ч, сонсогддог, тэр нь чамд ач тустай. Гуань Инь арга гэдэг нь аялгуу ажихийг хэлж байгаа юм. Энэ арга иймэрхүү асуудлуудыг шийдвэрлэхэд хамгийн хэрэгтэй байдаг юм.

Би чамайг энэ хогийн зуршилаасаа салж

өөрийн хайрыг цацуулсан гоо үзэсгэлэнт Үнэн дүрдээ орсонд тань баяртай байна. Чамд энэ нь илүү тохиромжтой юм, ийм сайхан залууд.

Тэгэхээр энэ залуу маш ухаантай бас сэтгэлийн тэнхээтэй юм. Ийм аймшигт дадал зуршилаас салахад тун хэцүү байдаг. Ийм зүйлтэй орооцолдчихвол бүх зүйл дуусаа л гэсэн үг. Mash олон хүмүүс сүйрчихдэг. Заримдаа тэд үүнийхээ талаар юу ч хийж чадахгүйгээсээ болоод амиа хөнөөх тохиолдол ч гардаг. Та бүгд мансууруулах бодисыг хичнээн зэвүүн болохыг мэднэ. Хар тамхинд орсон хүн “хоол”-гүй болохоороо, мансууруулах “хоол”-гүй үедээ тарчлан зовдог. Сая, сая зүү түүнийг дотроос нь хатгаж нөгөө юмаа цагт хэрэглэхгүй бол бүх л бие нь галд шатаж буй мэт мэдрэмж түүнд төрдөг. Үнэхээр аймшигтай, тэд үргэлж тарчилж байдаг. Эсвэл мянга мянган могой тэднийг хатгаж, тархийг нь дотроос нь идэж буй мэт санагдах гэх зэрэг олон зүйлийг мэдрэнэ. Ингэж л хар тамхи хүмүүсийн мэдрэлийг муутгаж, удаан аймшигт үхлээр үхүүлдэг.

Тиймээс хар тамхи наймаалдаг хүн бүр энэ дэлхийн хамгийн муу хүмүүс юм. Тэд нэг ёсны хорыг худалдаалж, хүмүүсийн тархи, энерги, залуу нас, үнэт ухаан санааг нь сөнөөж байна. Мансууруулах бодисны наймаачид үнэхээр аймшигтай. Хэрэв тэд дэлхий дахинд учруулж буй уршигаа мэддэг байсан бол зогсох байсан байх. Магадгүй тэд хар тамхины наймаачдын хувьд өөрсдөө тэрнийгээ хэрэглэдэггүй болохоор ухаарахгүй байгаа байх л даа. Тэд маш сайн мэдэж буй учир хэрэглэдэггүй юм. Тэдэнд үргэлж хангалттай нөөц байгаа учир хэрэглэсэн ч гэсэн тэд аянаа хордож үхэхээс л биш тарчилж үхдэггүй юм. Тэд хар тамхинаасаа болж үхнэ, тэгээд л гүйцээ. Хэтрүүлж хэрэглээд л хурдхан үхчихнэ, харин аймшигтайгаар тарчилж үхэхгүй. Тийм учраас тэд энэ дэлхийн залууст ямар хор хөнөөл учруулж буйгаа ойгохгүй байгаа юм.

Аймшигтай юм. Ямар аймаар болохыг нь харж байна уу? Нэгэнт ийм дадал зуршилтай болсон хүн үүнээсээ гарч чадах нь тун ховор. Үнэхээр хэлэхийн аргагүй

аймаар. Үргэлж дэлхий маань асуудалтай байх юм.

Үнэндээ мансууруулах бодис бол бидний хэрэглэхгүй байж болох зүйлсийн нэг юм. Тиймээс ч хэрэглэхгүй байх хэрэгтэй. Бид хүмүүст зовлон учруулахаас зайлсхийж мансууруулах бодис наймаалахгүй байж, хүмүүсийг хэрэглэхийг уриалахгүй байж ямар нэгэн байдлаар мансууруулах бодистой холбогдож, зарж худалдан, эсвэл санаандгүй хар тамхитай учирсан хүмүүсийг нууцлан далдалж золиос болгож болохгүй. Бид мансууруулах бодис, архи, тамхи гэх мэтчилэн зүйлсээс зайлсхийх хэрэгтэй. Энэ бол бидний зайлж чадах явдал учир, зайлсхийх хэрэгтэй. Мэдээж бид хэзээ ч, ямар ч шалтгаанаар үхэж болно. Гэхдээ бид өөртөө болон өрөөлд зовлонг түгээвэл, үйл түйтгэрийг нь эдлэх болно.

Дайн дажин ч гэсэн. Дайныг санаачилж тушаасан хүмүүс хамгийн хүнд үйл түйтгэрт унадаг. Хэрэв бид тамд очвол, олон янзын хүмүүсийг олж хардаг. Нэгэн өдөр та нар уйдаад тамд очиж “дэлгүүр” хэсэхээр шийдвэл өөрсдийн нүдээр харна биз. Бараг бүх л алдартан алуурчид тэнд байх бөгөөд үргэлж тарчлан зовж байдаг. Тэд амьд байхдаа сая сая, түм буман хүмүүст учруулж байсан сэтгэлийн зовлонгоо өөрсдөө амсаж байгаа нь тэр. Үүнийг л там гэж нэрлээд байгаа юм. Та нарыг чимхэж, сэрээдэж, хэрчиж татах чөтгөрийн хэрэг тэнд байхгүй. Та бүгдийн үүрдийн сэтгэлийн зовлон, гэмшил тань өдөр бүр та бүгдийг алахад хүрэлцэнэ. Хичнээн л олон хүний ална, хичнээн л олон хүний зовоож тарчлаана, төдий чинээ илүү зовлонг урт удаан хугацааны туршид эдлэх шалтгаан болж өгдөг.



Амьдралын дараах амьдрал

Авшигттан номын эзч Каролин Адамсон. Техас. А.Н.У

Зохиогч Раймонд А. Моддэй
Хэвлэсэн газар Bantam & Mockingbird books,
Жоржио. А.Н.У. 1975



1975 онд эхээрээ хэвлэгдсэн “Амьдралын дараах амьдрал” ном нь 5 жилийн туршид судлаж цуглуулсан 150 хэрэг явдлын эмхтгэл юм. “Клиник үхэл” буюу “Түр зуурын үхэл” -ийг туулан өнгөрсөн хүмүүс бүгд үхэлд ойрхон очсон ахуй ойлголтоо зохиогчид нарийн тодорхой хүүрнэсэн байдаг. Болсон явдлууд нь олон талаараа их ижил төстэй байв. Өөрөөр хэлбэл биенээс салан гарахдаа амар амгалан болон нэгдмэл байх ахуй ойлголтыг амссан байна. Тэднийг оршихуйн өөр ертөнцөд очиход нь тусалсан өөр нэгэн “хүний” талаар судалгаанд оролцсон ихэнх хүмүүс ярьдаг. Ийм төрлийн ахуй ойлголт нь: Хүн бие маш бодийн хувьд үхлийн хамгийн эцсийн шатандаа хүрэхэд үхчихлээ гэдэг

үгийг эмчээсээ сонсдог. Чангаар жингэнэн дүнгэнэх дуу чимээтэй нэгэн зэрэг, уртаас урт харанхуй хонгилоор асар хурдан нэвтрэн гарахыг өөрөө мэдэрдэг гэнэ. Тэгээд тэр, гэнэт махан биеийнхээ гадна өөрийгөө байхыг олж хардаг байна. Аль эрт нас барсан нایз нөхөд, садан төрлийн хүмүүсийн сүнснүүд түүнийг угтан авахаар ирж, гэрэл цацуулсан халуун дулаан, хайр энэрэл дүүрэн Төрөлтөн түүний өмнө гарч ирдэг байна. Тэрхүү Төрөлтөн өөрийн тань өнгөрүүлсэн амьдралаа үнэлж дүгнэх эсэхийг үг дуугүй асуугаад амьдралынх нь гол гол үйл явдлуудыг дэлгэн дүрсээр давтан үзүүлдэг байна.

Энэ бүхний дараа нэвтрэн гарах аргагүй хана хэрмэнд тулж ирээд цаг нь хараахан болоогүй, Дэлхийрүүгээ буцах ёстой гэдгээ

олж мэддэг. Баяр жаргал, хайр энэрэл, эрх чөлөө, амар амгалангийн мэдрэмжинд умбасан тэрээр эсрүүцэвч хүчинд автан буцахаас өөр аргагүй болдог байна. Сүүлд нь гэр бүл болон найз нөхөддөө энэ бүх болсон явдлаа ярих гэж ороловч хүний хэлээр дүрслэн тайлбарлахын аргагүй

болохыг ухаардаг. Бусад хүмүүс түүгээр тохуурхан дооглох болохоор энэ тухай ярихаа болидог байна.

Гэвч үхэл болон амьдралын талаархи энэхүү ахуй ойлголт нь түүний амьдралд ялангуяа үзэл бодолд нь гүн гүнзгий нөлөөлснийг мэдэрдэг юм.



Бяцхан Авшигттан

Билиг Оюуны Замд Орсон Азтай Гэр Бүл

Бяцхан авшигттан Чуанд Юу Чинг. 12 настай. Тайлзий. Формоса.

Би авшиг хүртээд олон жил болж байна. Цэцэрлэгт байхдаа би Багшдаа маш ихээр итгэдэг байсан учир авшиг авах хүсэлтээ эцэг эхдээ тавьсан. Багштай учрахаас өмнө эцэг маань их түргэн ууртай, хурц зантай, бидэнд уураа гаргадаг байлаа. Гэвч авшиг хүртсэнийхээ дараа ширүүн авирлахаа болж бид үймэж сахилгагүйдэх үед ч тэр зөвхөн “Томоотой байцгаа” гэж л хэлдэг болсон. Урьд өмнө нь ээж хэзээ ч хоол хийдэггүй. Бидэнд дандаа гаднаас хоол худалдан авчирч өгдөг байлаа. Харин одоо цөөхөн ч гэсэн цагаан хоол, бялууг яаж аятайхан

хийхийг сурчихаад бидэнд үргэлж хийж өгдөг болсон. Түүний хоолыг идэхдээ бид ямар их баяртай байдаг гэж санана! Дүү охин бид хоёр хичээлдээ тааруухан сурдаг байлаа. Гэвч авшиг авсанаас хойш бясалгалаа хийснээр саяханы шалгалтанд ахиц гарган сайжраад байгаа. Мөн миний эрэгтэй дүү гашуун эм уухасаа айдаг байсан бол одоо тоохоо больсон. Манай гэр бүлийн энэ бүх агуу их өөрчлөлтүүд Арьяабалын номын цогцостой холбоотой. Бидний үйл үрийг багасган бид бүгдийг асран хамгаалахын тулд хичээл зүтгэл гаргаж байгаад тань баярлалаа Их Багшaa.




Таны Толоо Гэрэлтэн Асч Буй Дэнлуу

Авшигтман номын эзч Мон-Ез. Тайпэй. Формоса.

Танил дотнохон санагдах тэр нэгэн орон зайд
Таны цухам сайтар мэдэх тэр л нутагт
Чилэхийг үл мэдрэн дэнлүүгээ өргөсөөр
Чин үнэнчээр таныг Тэр хүрээнэ

Тэнгис далайд хязгаар гэж үгүй
Тэнгэр огторгуйд төгсгөл гэж үгүй
Энэхэн хорвоод, танд минь хүрээс гэж үгүй
Эрх дураараа зогсолтгүй тэмцүүлсээр
Эцэж ядрах цаг нь харин ирвэл
Эргэж хурган харамсалгүйгээр
Эргээд очих нутагт тань
Ивэлгэн уярааж, эгнэгт болгоох
Ижий Түүний тань гэрэлт хайр бий

Хэнийг ч алагчлалгүй өөрийгөө зорон
Хэзээ ч мөхөншгүй асах тэр дэнлиу
Хэрэн хэсүүчилсээр та амьдралд түүртэж
Хичнээн зүдэрлээ ч бүү гутар,
Тэрийн тань бүлээн дулаан хойморт
Гэрэлтэн бадрах дэнлиу туяарсаар л байгаа
Тэвчээр алдарч, горьдлого тасралгүй
Таныг тэр хүрээсээр л буй.



С Я Р У У Н А Й Р А Г

Би Хэн Бэ?

Харанхуй хүчсан тэр бүрэнхий үдиээр
Хуйлран эрчилэх салхины чимээ чихнээ
сонстоно

Би энэхэн салхи билээ.

Харанхуйд дүүлэн нисэх салхи мэт
Хорьж дийлдэшигүй, үл туйлдах
Би энэхэн сүнс билээ.

Холын холд гялалзан анивчих
Хорвоогийн тод гэрэлтэх оддын дундах
Би ямар нэгэн зүйлийг хүсн буй
Гэгэлхэн ганцаардмал од билээ би
Гэвч юу юм бол?
Зүрх сэтгэлд минь шаналал илэрч
Зүйрлэшигүй таныхаа л гэрэлт инээмсэглэл
Бадрам дулаан нөмрийг тань үгүйлж байна.
Бээтгэри өнчирсөн навч салхинд хийснэ
Би тэрхэн навч билээ
Гэрэлтэн цацарч наашлан ойртох гэрэл буй
Би тэр л гэрэл билээ.
Буцаж эргэн санан дурсах
Би дүүрэн орчлон билээ.
Би бүх л ертөнцийг мэдээрч байна.



Их Багш Чин Хайн “Мэдээ” сэтгүүлийн 85-дахь дугаараас орчуулан
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгээс
эрхлэн гаргав.

Зөвшөөрөлгүй олшируулан хэвлэхийг хориглоно.

2006 оны 4 сар



Хүүхдийн зүрх сэтгэл

Авшигтан номын ах Стефан Агуларын зураг болон тайлбар Мөн түүний эх
Лаура Агулар.

Коста Рика

Хуухдуудээ, Наашаа ирцгээ! томчууддаа зааж сургацаа. Яагаад гэвэл тэд биднээс жаахан юм. Тэд Бутээлийг хайрлах хайраа алдчихсан юм. Энэ нь тэдний буруу биш! Бурханаас холдсон учир тэд оорсдийн Цорын ганц Үнэн, Эрхэм зорилгоо мартан их эргүүлэгт уначихсан юм.



Энэ буланд нэгэн билгүүн ухаант хүн зогсож байна. Тэр хөдөлморлохдоо чин сэтгэлээр залбирч, сайхан сэтгэлээр олсон бүхнээ бусадтай хуваалцдаг юм.

Сахиулсан Тэнгэрийн Жигүүр

(өндөргүй, гүзээлзгэнэтэй бялуу)

"Сахиулсан Тэнгэрийн Жигүүр" нарийн боовыг авшигтаж ирвлийн эхт Я.мазаки, Япон, Гүн.на



1. Нарийн боовны гурил
2. Цэвэр крем
3. Сүүр
4. Чихрийн пудр
5. Амталсан хоолгогч (baking powder)
6. Нуунтагласан чихэр
7. Өтгөн зоохий
8. Цагаан хоолтын маргарин
9. Гүзээлзгэн

Нэг дугуй торт 15см (16инч)

Ориц:

1. Глутин багатай (Нарийн боовны гурил) 154гр (1 1/4 аяга)
-bakery powder 10гр (2 1/2 цайны халбага) амталсан хоолгогч
- чихрийн пудр (нуунтагласан элсэн чихэр) 60гр (1/2 аяга)
- ургамлын маргарин 50гр (Том хоолтын халбага 4)
- цэвэр крем 30гр (цайны халбага 4)
- сүү 120мл (1/2 аяга)
- цоцгий 300мл өтгөн крем (1 1/4 халбага)
- нунтагласан элсэн чихэр 16гр (цайны халбага 3)
- гүзээлзгэн 20 орчим

Хийх арга:

Гурил, хоолгогч, нунтаг чихрээ холино. Маргаринаа халаагаад крем сүүгээ хийнэ. Маргарин хайлтал халаагаад авна. Хөрсний дараа зуурагч машиндаа хийгээд дээр нь хольсон гурилаа хийж сайн зуурна. Хэвэндээзориулатынцаас хийгээд зуурмагаахийнэ.

Халааж бэлдсэн зуухандaa 160°c (320 F- шарах шүүгээ болгон өөр өөр хэмээсүүртэй байдаг)
- 20 мин, 150°c (300 F) 10 мин шараад гаргаж аван хөргөөд, 1 см-ийн зузаантайгаар 3 хэсэг хавтгай болгоож зүснэ. Кремээ нунтагласан чихэртэйгээ хамт түрхээд гүзээлзгэнэ тавиад гурвууланг нь торт хэлбэрт оруулж давхарлана. Кремээ дахин тавинаа. Ингээд амтат бялуу бэлэн боллоо. Илүү амт орууляа гэвэл 1 хоолны халбага vanilip (ванилин) нэмж хийж болно.

